

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2026.06.25

Улаанбаатар хот

Авлигатай тэмцэх газар Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр эхний хагас жилд дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

1.1 Захиргааны удирдлагын чиглэлээр-Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний дүн, Авлигатай тэмцэх хөтөлбөр, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө болон холбогдох бусад бодлогын баримт бичгүүдийг үндэслэн баталж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа.

“Монгол Улсын авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2025”-ын талаарх мэдээлэл, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн нэгдсэн тайлан, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн мэдээлэл”-ийг эмхэтгэн Авлигын эсрэг хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг баримтлан Улсын Их Хуралд хүргүүлээ.

Авлигатай тэмцэх газрын стратеги (2026-2030 он), “Авлигатай тэмцэх газрын Хүний нөөцийн төлөвлөлтийн баримт бичиг”, “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн сургалтын хөтөлбөр”, “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр” буюу бодлогын баримт бичгүүдийг баталж, зорилго, зорилтыг тодорхой болголоо.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын Зүүн Европ, төв Азийн Авлигын эсрэг сүлжээний бүгд хуралд танилцуулагдсан Истанбулын Авлигатай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 5 дугаар шатны мониторингийн тайланг хүлээн авч, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулж байна.

Засгийн газрын 2025 оны 23 дугаар тогтоолын дагуу хийгдсэн “Төрийн ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хийсэн улсын үзлэг”-т хамрагдах бэлтгэл ажлыг ханган Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан “Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа”, “Төрийн байгууллагын архивын үйл ажиллагаа”, “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт” гэсэн 3 үндсэн аргачлалын дагуу 2020-2025 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримт бичгүүдийг эмхлэх, цэгцлэх, албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг хангах болон холбогдох бусад арга хэмжээ авч ажиллалаа. Төрийн ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны улсын нэгдсэн үзлэгээр дунджаар 92.5 оноо (А)-той дүгнэгдсэн бөгөөд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Эрүүгийн хуульд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураах тухай хууль, Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн төслийн ажлын хэсэгт эрх бүхий албан тушаалтан ажиллаж байгаа бөгөөд эдгээр хууль болон Санал худалдан авалтын эсрэг хуулийн төсөл, Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах тухай хуулийн төсөл, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох хууль, журмын төсөлд тусгавал зохих саналуудыг хууль санаачлагчид болон УИХ, ЗГХЭГ, ХЗДХЯ зэрэг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлав.

Байгууллагын дотоод үйл ажиллагааг зохицуулж байгаа 15 эрхийн актад нэмэлт, өөрчлөлт оруулж, 5 актыг шинэчлэн найруулж, батлан мөрдүүлэв.

Үндэсний аудитын газраас Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын хяналт шалгалтаар “Өөрчлөлтгүй” дүгнэгдлээ.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасныг баримтлан байгууллагын мэдүүлэг гаргавал зохих албан хаагчдын 2025 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа болон албан тушаалтнуудын 2025 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн шинэчилсэн бүртгэлийн тухай мэдээллийг Улсын Их Хурлын Хууль зүйн Байнгын хороонд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 73 дугаар зарлигаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийг мэдээллээр хангах журам”- зааснаар холбогдох мэдээ, мэдээллийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд, ХАСХОМ-ийн тайлан, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэргийн статистик мэдээг боловсруулан Үндэсний статистикийн хороонд, мэдээллийн технологийн чиглэлээр 2020-2026 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний тайланг УИХ-ын Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хороонд, Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасны дагуу төрийн болон албаны нууцыг хадгалах, хамгаалах чиглэлээр 2025 онд гүйцэтгэсэн ажлын тайланг Тагнуулын ерөнхий газарт зохих журмын дагуу тус тус хүргүүлж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллав.

Бусад иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас 6669 албан бичиг хүлээн авч, бусад иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 9133 албан бичиг илгээж, орон нутгийн шууданд болон бусад албан байгууллагад давхардсан тоогоор 12547 баримт бичиг хүргэсэн байна.

Архивын баримтад нягтлан шалгалт хийх, тоо бүртгэл хөтлөх, тооллого явуулах үүргийн тухайд Газрын даргын 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн А/34 дугаартай тушаалаар “Байгууллагын архивд хадгалагдаж байгаа хадгаламжийн нэгжийн тоо хэмжээг тогтоох, нягтлан шалгалт хийх, сэргээн засварлах шаардлагатай баримтыг илрүүлэх зорилгоор архивын баримтад тооллого хийх, баримтуудыг цахим хэлбэрт шилжүүлэх” ажлын хэсгийг томиллоо. Тус ажлын хэсгээс архивын 379 хадгаламжийн нэгжийг архивын сканердан, байгууллагын архив, албан хэргийн ARMS программд дотоод товёогтой холбосон. Архивын 947 боть, 76184 хуудас баримтад тооллого хийн бүртгэл хөтлөөд байна.

Байгууллагын хэмжээнд 2026 оны эхний хагас жилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас гаргасан 1844 гомдол, мэдээлэл хүлээн авсныг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, өргөдөл, гомдол, мэдээлэл 331 нэгжээр буюу 21,9 хувиар, түүний дотор авлига, ашиг сонирхлын талаарх гомдол, мэдээлэл 162 нэгжээр буюу 34,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

1.2 Гадаад харилцааны чиглэлээр-2026 оны эхний хагас жилд байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, олон улсын өмнө хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлэх, Авлигын эсрэг конвенцыг хэрэгжүүлэх чиглэлээр олон улсын болон гадаад улсын ижил чиг үүрэг бүхий байгууллагатай нягт хамтран ажиллалаа.

Бүгд Найрамдах Узбекистан улсын Авлигатай тэмцэх агентлагтай авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, нийтийн алба, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар хамтын ажиллагааг өргөжүүлэх, сайн туршлага солилцох, албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх, хамтарсан сургалт, судалгаа зохион байгуулах чиглэлээр “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулж, Санамж бичигт Монгол Улсын Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа, Бүгд Найрамдах Узбекистан Улсын Авлигатай тэмцэх агентлагийн дарга, доктор Акмал Бурханов нар гарын үсэг зурлаа.

2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр Бүгд Найрамдах Казахстан Улсын Үндэсний аюулгүй байдлын хорооны дэргэдэх Авлигатай тэмцэх албаны төлөөлөгчидтэй цахим уулзалт хийж, хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэх, авлигатай тэмцэх чиглэлээр туршлага солилцон, цаашид “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг байгуулах бэлтгэлийг ханган ажиллаж байна.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (OECD)-ын Зүүн Европ, Төв Азийн Авлигын эсрэг сүлжээ (ACN)-ний Үндэсний зохицуулагчаар УССГХ-ийн дарга, эрхэлсэн комиссар Б.Энхмэндийг томилж, тус байгууллагад албан ёсоор мэдэгдэв.

Бүгд Найрамдах Узбекистан Улсын Ташкент хотноо 2026 оны 5 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Авлигын эсрэг VI форум болон Авлигын эсрэг

санаачилгын хууль сахиулах байгууллагуудын сүлжээ (ACI LEN- Anti-Corruption Initiatives Law Enforcement Network)-ний уулзалтад АТГ-ын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа тэргүүтэй төлөөлөгчид, Бүгд Найрамдах Казахстан Улсын Астана хотноо 2026 оны 6 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулагдсан “GovHR Forum 2.0: Дижиталчлал ба хиймэл оюун ухааны эрин үе дэх Хүн, чадавх, нийгмийн үнэт зүйлс” арга хэмжээнд Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар З.Баасанням тэргүүтэй төлөөлөгчид тус тус оролцож, төрийн байгууллагын ил тод байдал, хариуцлага, дижитал шилжилтэд суурилсан авлигаас урьдчилан сэргийлэх тогтолцоо, бүс нутгийн хамтын ажиллагаа, авлигын эсрэг боловсрол, нийгмийн түншлэлийн асуудлаар хэлэлцүүлэг өрнөсөн хэлэлцүүлэгт саналаа илэрхийллээ.

Дараахь хоёр талт уулзалтууд зохион байгуулагдаж, Авлигатай тэмцэх газраас авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигын гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр баримталж байгаа бодлого, үйл ажиллагаа, үр дүнгийн талаар танилцуулж, мэдээлэл цаашдын хамтын ажиллагааны талаар санал, мэдээлэл солилцлоо. Тухайлбал,

- АТГ-ын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа, Дэд дарга, эрхэлсэн комиссар Г.Азжаргал нар 2026 оны 1 дүгээр сарын 15, 29-ний өдрүүдэд АНУ-ын Элчин сайдын яамны Дипломат аюулгүй байдлын албаны Мөрдөх ажил хариуцсан атташе Клиффорд Китто болон тус албаны Хууль сахиулах ажлын зөвлөх П.Даваажаргал нарыг хүлээн авч, уулзав.
- Дэд дарга, эрхэлсэн комиссар Г.Азжаргал:
 - 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр АНУ-ын Элчин сайдын яамны Бүс нутгийн аюулгүй байдлын хэлтсийн дарга Сара Бет Машл, INL хөтөлбөрийн мэргэжилтэн Ц.Эрдэнэхишиг нарыг хүлээн авч уулзан АНУ-ын Хууль зүйн яамны Шуурхай хариу арга хэмжээний сан (DOJ Rapid Response Fund)-ийн дараагийн үе шат болон C4ADS төслийн өргөтгөлийн талаар хэлэлцэж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцсоны дээр дараагийн шатны төсөлд тусгуулах саналыг хүргүүлэв.
 - 2026 оны 5 дугаар сарын 13-ны өдөр НҮБ-ын МБГХТА-ны Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын тэргүүн Дук Лонг Нгүеэн болон албаны бусад төлөөлөгчийг хүлээн авч, уулзан “Ази дахь ашигт малтмалын салбарын хяналт ба нийлүүлэлтийн сүлжээний ил тод байдлыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд санал солилцож, хамтран ажиллахаар тогтлоо.
 - 2026 оны 6 дугаар сарын 2-ны өдөр АНУ-ын Бээжин дэх Элчин сайдын яамны хуулийн атташе Томас Пауэлл, хуулийн туслах атташе Хсиан Ван, АНУ-ын Дотоод орлогын албаны Эрүүгийн мөрдөн шалгах алба (IRS-CI)-ны төлөөлөгч Жорж Бабикутти болон албаны бусад төлөөлөгчийг хүлээн авч уулзан, цаашдын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, сургалт, туршлага солилцоог нэмэгдүүлэх чиглэлээр санал солилцож, цаашид хамтран ажиллахаар ярилцаж тохирлоо.
 - 2026 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Олон Улсын Валютын Сан (IMF)-ийн Монгол Улсыг хариуцсан ажлын хэсэг Дүрмийн IV заалтын хүрээнд гишүүн орнуудын эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдалд үнэлгээ хийх, макро эдийн засгийн эрсдэл, эмзэг байдлыг тодорхойлох, цаашдын бодлогын зөвлөмж боловсруулах ажлын хэсгийн төлөөлөгчдийг хүлээн авч, уулзан Авлигатай тэмцэх газраас хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээ, үр дүнгийн талаар ярилцаж, санал солилцов.
 - ОУВС-гийн Ази, Номхон далайн газрын дэд захирал, Монгол Улсыг хариуцсан ажлын хэсгийн ахлагч ноён Тахсин Саади тэргүүтэй төлөөлөгчидтэй санал солилцож, мэдээлэл өглөө.
- Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар З.Баасанням 2026 оны 2 дугаар сарын 3-ны өдөр “Дэлхийн шударга ёсны төсөл” олон улсын байгууллагын Ази, Номхон далайн бүс нутаг хариуцсан захирал Спирак Плипатыг, ГАХ-ийн дарга, эрхэлсэн комиссар Р.Баярмагнай 2026 оны 2 дугаар сарын 2-ны өдөр Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны

байгууллага (OSCE)-ийн төлөөллийг, ХШДШХ-ийн албаны дарга, ахлах комиссар Б.Баярсайхан 2026 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Шүүхийн сахилгын хорооны шинжээчид болон Твиннинг буюу “Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь” төслийн ажлын хэсгийн төлөөлөгчдийг хүлээн авч уулзан “Болзошгүй авлига, сахилгын хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэмэгдүүлэх” сэдвийн хүрээнд мэдээлэл харилцан солилцож, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцов.

Хоёр. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030), түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах, улсын хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах хяналт тавих, зөвлөмж өгөх, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, тайлан мэдээг нэгтгэх, хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх ажлыг хариуцан гүйцэтгэж байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2025 онд хэрэгжүүлэхээр 150 арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд хэрэгжүүлэгч байгууллагуудаас ирүүлэн тайланг нэгтгэн нэгдсэн тайланд ЗГХЭГ-тай хамтран Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 2025 оны хэрэгжилт дунджаар 66,8 хувьтай үнэлэгдлээ.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг нэг мөр зохион байгуулах зорилгоор 2024 оны үр дүнг танилцуулах, 2025 оны биелэлтийг тайлагнах, 2026 оны арга хэмжээг төлөвлөх, хөтөлбөрийн зорилго тус бүрийн үнэлгээний аргачлалыг танилцуулах, нэг мөр ойлголтод хүргэх зорилгоор УИХ-ын дэргэдэх байгууллага болон Засгийн газрын харьяаны бүх яам, агентлаг болон нутгийн захиргааны байгууллага зэрэг нийт 98 байгууллагын тайлан гаргах, баталгаажуулах эрх бүхий нийт 235 албан хаагчийг хамруулж сургалт, хэлэлцүүлгийг үе шаттайгаар зохион байгуулав.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилтийн үнэлгээг хэрэгжүүлэгч байгууллагуудад танилцуулах, 2026 оны хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудтай уулзалт хийж байна. Улсын ерөнхий прокурорын газар, Үндэсний аудитын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Монголбанк, ЗГХЭГ, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсролын яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Эрүүл мэндийн яам, Гадаад харилцааны яам, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газрын Шадар сайдын Ажлын алба, Стратеги судалгааны хүрээлэн, Монополын эсрэг газар, Стандарт, хэмжил зүйн газар, Цагдаагийн ерөнхий газар, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Төрийн худалдан авах ажиллагааны газар зэрэг байгууллагын удирдах болон асуудал хариуцсан албан хаагчидтай уулзаж, арга зүйн зөвлөгөө өглөө.

• Хөтөлбөрийн Зорилго 1 (“Улс төрийн хүрээнд авлигатай тэмцэх хүсэл зориг, хүчин чармайлт, манлайлал, ил тод байдлыг төгөлдөршүүлнэ.”-ийн Сонгуулийн үеэр санал худалдан авахад чиглэсэн бүх хэлбэрийг хориглож, хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг бүрдүүлэх Зорилт 1.1, Улс төрийн нам, түүний хандивын санхүүжилт, гишүүнчлэлийн татвар, сонгуулийн кампанит ажлын зардлын хяналт, ил тод байдлыг хангах тогтолцоог бэхжүүлэх Зорилт 1.2-ийн тухайд Монгол Улс нь Албани, Гана, Норвег улстай хамтран “Улс төрийн нам, сонгуульд нэр дэвшигчид болон сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх тухай” түүхэн дэх анхны бие даасан тогтоолын төслийг санаачилсан юм. Уг тогтоолыг 2025 оны 12 дугаар сард Доха хотноо хуралдсан Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын оролцогч талуудын 11 дүгээр бага хурлаар (CoSP11) конвенцын гишүүн 192 орон 100 хувь нэгдсэн зөвшилцлөөр баталсан. Энэ нь иргэд улс төр, сонгуулийн үйл явцын санхүүжилтийн талаар мэдэх эрхтэй гэсэн зарчмыг дэлхийн хэмжээнд анх удаа албан ёсны стандарт болгон бататгасан бөгөөд НҮБ-ын Дохагийн конвенцын шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд холбогдох саналыг хүргүүлсэн нь Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 220 дугаартай тогтоолоор баталгаажив. Энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан ажил арга

хэмжээг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.

Хөтөлбөрийн 1.4.5-д заасан “Иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэн иргэд, сонгогчдын хяналт, хариуцлагыг сайжруулах чиглэлээр Иргэний нийгмийн байгууллагатай хамтын ажиллагаа хөгжүүлнэ.” арга хэмжээний хүрээнд Авлигатай тэмцэх зорилго бүхий иргэний нийгмийн байгууллагын сүлжээ, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх” арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор “Нийгэм улс төрийн боловсрол” НҮТББ-тай хамтран их, дээд сургуулийн оюутнуудад зориулсан “No Price Tag On Me” сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж, 350 орчим оюутныг санал худалдан авалтаас урьдчилан сэргийлэх мэдлэгээр хангав. Мөн “Эмэгтэйчүүд, залуучуудын оюуны сан” НҮТББ-тай хамтран “Авлигаас ангид Төрийн алба-менторшип хөтөлбөр”-ийн 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, хөтөлбөрийг амжилттай төгссөн 24 хүнд “ментор”-ын гэрчилгээ олгосон.

Төрийн өндөр болон улс төрийн албан тушаалтан авлигын хэрэгт яллагдагчаар татагдсан үед улс төрийн дэмжлэг үзүүлэх боломжийг хязгаарлах судалгааны тайланд нэмэлт, өөрчлөлт оруулахаар судалгааны багтай санал солилцлоо.

Зорилт 1.5-ийн “Улсын Их Хурлын гишүүн өөрөө эцсийн өмчлөгч, эсхүл нөлөө бүхий хувьцаа эзэмшдэг хуулийн этгээдийн явуулж байгаа аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн төсөл санаачлах, санал гаргахыг хязгаарласан эрх зүйн орчныг бүрдүүлнэ” араг хэмжээний хүрээнд авлигын гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан төрийн өндөр болон улс төрийн албан тушаалтанд улс төрийн дэмжлэг үзүүлэх боломжийг хязгаарлахад чиглэсэн хууль тогтоомжид шинээр тусгуулах санал, зөвлөмж, судалгааны тайланг хүлээн авч, судалгааны багтай хамтран ажиллаж байна.

• Хөтөлбөрийн 2 дугаар зорилгын Зорилт 2.1 “Төрийн албаны хүний нөөцийн удирдлага болон томилгооны ил тод, мэргэжсэн, тогтвортой байдлыг бэхжүүлнэ”, 2.1.4.3-т заасан Авлигын эрсдэлтэй албан тушаалд томилогдох нэр дэвшигчийг сонгон шалгаруулах, сэлгэн болон шилжүүлэн ажиллуулах тогтолцоог бий болгох арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох санал боловсруулах үүрэгтэйгээр Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 156 дугаар тушаалаар зохион байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд эрх бүхий албан тушаалтан ажиллаж байна. Тус ажлын хэсгээс 4 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, авлигын эрсдэл бүхий албан тушаалыг судлан тодорхойлох, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулах, батлуулах, мөн тухайн албан тушаалд томилогдох нэр дэвшигчийг сонгон шалгаруулах, сэлгэн шилжүүлэн ажиллуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтын талаар санал солилцож ЗГХЭГ-т авлигын эрсдэлтэй албан тушаалыг тодорхойлох эрх зүйн зохицуулалт бий болгох, авлигын эрсдэлтэй албан тушаалыг тодорхойлох шалгуур, аргачлалыг тогтоох, авлигын эрсдэлтэй албан тушаал эрхэлж буй албан хаагчид тавих хяналт, урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох саналыг хүргүүлэхээр шийдвэрлэсэн болно.

Зорилт 2.3 “Нийтийн албан тушаалтан зарлагаа мэдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, татварын болон төрийн бусад мэдээлэлтэй уялдуулан хяналт тавих цахим системийг хөгжүүлнэ.” 2.3.2 Мэдүүлгийн бүрдүүлэлт, хяналт шалгалтын үйл ажиллагаанд төрийн байгууллагын мэдээллийг бүрэн ашиглаж, эрсдэлд суурилсан цахим систем хөгжүүлнэ.” арга хэмжээг хэрэгжүүлэхээр зорилгоор:

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, хөрөнгө орлогын мэдүүлгийн (COIAD) бүрдүүлэлтийн системийг сайжруулах, Монгол Улсын Авлигатай тэмцэх газрын албан тушаалтнуудын ашигладаг тоног төхөөрөмжийг худалдан авах мэдээллийн системийг нийлүүлэх, суурилуулах, үйл ажиллагаанд нэвтрүүлэх зорилгоор 2025 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Авлигатай тэмцэх газар, “Ай ти зон” ХХК гурвалсан гэрээ байгуулсан байсан. Энэхүү гэрээний дагуу системийн хөгжүүлэлт хийснээр:

- 2025 оны 12 дугаар сард “Мэдүүлэг бүрдүүлэлтийн болон Хяналт шалгалтын цахим систем”;
- 2026 оны 4 дүгээр сард ХАСУМ-ийг цахимаар хүлээн авах, хянах, хариу хүргүүлэх дэд хэсэг;

- 2026 оны 5 дугаар сард Мэдүүлгийн ил тод байдлын цахим системийг үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлээ.

Системийн алдаа, доголдлыг засварлах, техникийн дэмжлэг үзүүлэх үе шат 2027 оны 07 дугаар сарын 30-ны өдөр хүртэл үргэлжилнэ.

Системийг үйл ажиллагаанд нэвтрүүлснээр мэдүүлэг бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд дараах ахиц дэвшил гарлаа. Үүнд:

- Нийтийн албан тушаалтан мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар гаргах, бүртгэх, хадгалах үйл ажиллагаа цааснаас бүрэн цахим хэлбэрт шилжсэн.
- ХАСУМ-ийг цахимаар гаргаж, томилох эрх бүхий байгууллагуудтай цахимаар харилцан мэдээлэл солилцдог болсноор бичиг хэргийн зардал, хугацааг эрс хэмнэсэн.
- Маягт бөглөх стандарт шаардлага нэмэгдэж, мэдүүлэг гаргагч үнийн дүнгийн орон алдах алдаа гаргах эрсдэлийг бууруулсан.
- Системийн удирдлага (UI/UX) илүү хялбар болж, мэдүүлэг гаргагч болон Эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ) ашиглах нөхцөл сайжирсан.
- ЭБАТ-уудын нэгдсэн тайланг системээс шууд гаргадаг болсон бөгөөд мэдээллийн хадгалалт, хамгаалалт бүхий нэгдсэн цахим сан бүрдсэн.

Хяналт шалгалтын үйл ажиллагааны хувьд мэдүүлгийн эрсдэлийг систем автоматаар тооцож, мэдэгддэг алгоритм нэвтэрсэн. Хяналт шалгалтын танилцуулгын холбогдох хэсгүүдийг автоматаар үүсгэдэг болсноор ажлын ачааллыг хөнгөлж, цаг хэмнэх боломж бүрдсэн. ХАСУМ-ийг хүлээн авах, хянах, хариу хүргүүлэх бүх процесст цаас ашиглахгүй болсон нь процесст зарцуулах хугацааг бууруулж, ачааллыг бууруулан, 100 гаруй сая төгрөгийн бичиг хэрэг болон шуудангийн зардлыг хэмнэх боломж бүрдсэн. Мөн хяналт шалгалт хийх албан хаагчдын хуваарилалтыг цахимаар хийдэг болсноор хүний оролцоо буурч, цаг хугацаа хэмнэх боломжтой болсон.

Ил тод байдал, олон нийтийн хяналтын тухайд хөрөнгө, орлогын мэдүүлгийн мэдээллийг машин унших боломжтой форматаар татаж авах, харьцуулах боломжийг бүрдүүлсэн. Иргэд, олон нийт мэдүүлгийн мэдээлэлтэй чөлөөтэй танилцах, харьцуулалт хийх боломж нэмэгдэж, авлигын эсрэг олон нийтийн хяналт тавих нөхцөл бодитоор хангагдлаа гэж дүгнэж байна.

Зорилт 2.6 “Салбарын эрсдэлийг оновчтой тодорхойлж, түүнд чиглэсэн арга хэмжээг үе шаттайгаар, цогц байдлаар хэрэгжүүлнэ”-ын хүрээнд Үндэсний шударга байдлын тогтолцооны суурь болон тулгуур баганын ил тод, хариуцлагатай, хараат бус, шударга байдлыг үнэлэх ажлыг зөвлөх баг, судлаачдаар гүйцэтгүүлж, тайлан, зөвлөмжийг салбарын байгууллага, мэргэжилтнүүдэд танилцуулах хэлэлцүүлгийг үе шаттай зохион байгуулав. “Хувийн хэвшил”, “Төрийн өмчит хуулийн этгээд”, “Иргэний нийгэм”, “Хэвлэл мэдээлэл”, “Сонгуулийн төв байгууллага”, “Улс төрийн нам”, “Аудитын дээд байгууллага”, “Шүүх засаглал”, “Хууль тогтоох засаглал”, “Гүйцэтгэх засаглал” зэрэг 10 тулгуур баганын хэлэлцүүлэгт нийт 178 төлөөлөл оролцож, тайлангийн төсөлд санал өгснийг нэгтгэн тайланд тусгалаа.

Салбар дахь үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх аргачлалыг боловсруулж, үнэлгээ хийх 2.6.1-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсролын болон эрүүл мэндийн салбарын авлигын эрсдэлийг үнэлэх аргачлал боловсруулах ажлыг зохион байгуулж байна. Тухайн аргачлалыг боловсруулах гүйцэтгэгч нартай гэрээ байгуулж, мэргэжил, араг зүйн зөвлөгөө, мэдээллээр ханган, үйл ажиллагаанд хяналт тавин хамтран ажиллаж байна. Мөн авлигын эрсдэлийн үнэлгээний арга зүй, жишиг аргачлалуудын талаар сургалтыг зохион байгуулж, арга зүйн нэгдсэн ойлголтыг өглөө. Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 50 хувьтай байна.

“Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлттэй уялдан хүний эрхэд үзүүлэх үр нөлөөний талаарх судалгаа”-ны хүрээнд авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийн явцад хүний эрхэд үзүүлж буй нөлөөлөл, тулгамдсан асуудал, тэдгээрийн шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийж, авлигын гэмт хэргийн мөрдөн шалгах, прокурор, шүүхийн шатны ажиллагаанд хүний

эрхийн эрсдэл үүсэж болзошгүй нөхцөл, хүчин зүйлсийг тодорхойлж, тэдгээрийг бууруулах чиглэлээр хууль, эрх зүй, бодлого, үйл ажиллагаанд тусгах санал, зөвлөмж бүхий судалгааны тайланг боловсруулж байна. Ажлын гүйцэтгэл 80.0 хувьтай үргэлжилж байна.

Шударга байдлын үнэлгээгээр хамгийн бага оноо авсан 10 байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч хамтран ажиллаж байна. Боловсролын яам (60.2 оноо), Эрүүл мэндийн яам (63.2 оноо), Мал эмнэлгийн ерөнхий газар (63.8 оноо), Байгаль орчин, уур амьсгалын яам (64.7 оноо), Баянхонгор аймаг (64.7 оноо), Дорнод аймаг (62.5 оноо), Ховд аймаг (62.6 оноо), Баян-Өлгий аймаг (65.2 оноо), Архангай аймаг (66.4 оноо), Дархан-Уул аймаг (67.7 оноо) зэрэг байгууллагууд үнэлгээг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн тусгайлсан төлөвлөгөө баталсан бөгөөд хэрэгжилтийг хангах үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хяналт тавин ажиллаж байна.

• Хөтөлбөрийн Зорилго 3 (Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэн, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн бодит оролцоо, үр дүнтэй хяналтыг бэхжүүлнэ.)-ын хүрээнд:

НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн XX-ийн “Интегра” санаачилгын хүрээнд “Монгол Улсад орон нутгийн уул уурхайн гэрээний ил тод байдал, хариуцлагатай байдлыг сайжруулах нь” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэв. Захиргааны байгууллага болон тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн хооронд байгуулсан орон нутгийн гэрээнд хийсэн дүн шинжилгээний үр дүн, шинэчилсэн загвар гэрээний төслийг танилцуулах хэлэлцүүлгийг 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулж, танхим болон цахимаар нийт 64 оролцогчийг хамрууллаа.

Сангийн яамнаас боловсруулж буй “Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах нийтлэг стандарт, агуулга, мэдээлэл тавих журам”-ын шинэчилсэн төслийг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх араг хэмжээний төлөвлөгөөний 3.4.3.1-д заасан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн шилэн дансны мэдээлэлд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчтэй байгуулсан гэрээ, төлсөн төлбөрийг тусгайлан мэдээлэх журам, стандартыг батлах” арга хэмжээтэй уялдуулах талаар холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж өгөв. Мөн Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын шинэчилсэн найруулгын төсөлд холбогдох саналыг тусгуулахаар хүргүүлснээс. Журмын 3.1.17-д “хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээ, төлбөрийн мэдээллийг 7 хоногийн дотор PDF форматаар нийтлэх” гэх санал төсөлд тусгагдав.

Зорилт 3.4 Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийг хамгаалах эрх зүйн орчныг бэхжүүлж, хариуцлагыг нэмэгдүүлнэ. “Сэтгүүлчийн мэргэжлийн хариуцлагыг нэмэгдүүлж, хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлнэ.” арга хэмжээг хэрэгжүүлэхээр “Хэвлэл мэдээллийн зөвлөл” НҮТББ-тай хамтран ажиллах гэрээ байгуулан тус зөвлөлийн гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны чанар, сэтгүүл зүйн редакцын ёс зүйн хариуцлага, ёс зүйн хороодын гишүүдийн чадавхыг бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүллээ.

• Хөтөлбөрийн Зорилго 4 (Хувийн хэвшилд авлигыг үл тэвчих соёлыг төлөвшүүлнэ.)-ийн Зорилт 4.1 (Бизнесийн ёс зүй, Комплаенсын сайн туршлагыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.)-ийн хүрээнд Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хувийн хэвшил дэх шударга байдлыг хангах “Авлигын эсрэг комплаенсын хөтөлбөрийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх” төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд төслийг МҮХАҮТ-ын Комплаенс, бизнесийн ёс зүйн зөвлөлийн гишүүдэд танилцуулан санал авч, 2 аж ахуйн нэгж дээр туршилт судалгаа хийлгүүлэх ажлыг гүйцэтгэснээр төслийн бэлтгэл, туршилтын үе шат хангагдсан.

Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид авлигын эсрэг бодлого, стандарт, Комплаенсын хөтөлбөр хэрэгжүүлэхийг хөхиүлэн дэмжих, урамшуулах зохицуулалтыг боловсронгуй болгох судалгааг гүйцэтгүүлж байгаа бөгөөд тус судалгааны багийн үйл ажиллагаанд хяналт тавин хамтран ажиллаж байна.

МҮХАҮТ-тай хамтран “Компанийн дотоод орчинд шүгэл үлээх орчны талаарх өөрийн үнэлгээ хийх аргачлал”-ын төслийг боловсрууллаа.

• Хөтөлбөрийн Зорилго 5 (Авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын хараат бус, бие даасан байдлыг хангаж, аливаа нөлөөллийн эрсдэлийг бууруулна.), Зорилт 6.3 (Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх замаар иргэдийн итгэл хүлээсэн шүүхийн тогтолцоог бэхжүүлнэ.)-ын хүрээнд:

Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран шүүгч, шүүхийн захиргааны ажилтан нарт бүсчилсэн сургалтыг Архангай, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Хөвсгөл аймаг болон Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх, нийслэл, дүүргийн нийт 269 шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудад сургалт хийлээ.

Шүүгчийн давтан сургалтад ашиглах видео хичээлийн хөтөлбөр боловсруулах ажил үргэлжилж байна.

• Хөтөлбөрийн Зорилго 6 “Авлигын гэмт хэргийн шинжийг хийдэлгүй тодорхойлох, хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.”-ын Зорилт 6.1-ийн 6.1.8-д заасан “Авлигын гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгийг хураах нэмэгдэл ялын төрөл бий болгох асуудлыг судалж, санал боловсруулна.” хүрээнд холбогдох судалгааг хийж байна.

“Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг тодорхой болгоно.” 6.4.6 дэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр эдгээр хуульд заасан нийтийн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгож өөрчлөлт оруулахаар төслийг боловсруулж байна.

• Хөтөлбөрийн Зорилго 7 (Төсөв, санхүү, аудитын хяналтыг сайжруулан, худалдан авах ажиллагааны авлигын эрсдэлийг бууруулна.)-ын Зорилт 7.3.1 “Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, төсөл сонгон шалгаруулалт, зарцуулалтыг ил тод, олон нийтийн хяналттай, хариуцлагатай болгож, олон улсын жишигт нийцүүлнэ.”-ын хүрээнд: Улсын авто замын санд авлигын эрсдэлийн үнэлгээ хийж, тайланг боловсруулж байгаа бөгөөд гүйцэтгэл 90,0 хувьтай байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 7.1.9.1, 7.3.4.1-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхээр бэлэн бус төлбөр тооцооны эзлэх хувийг нэмэгдүүлэх, төсвийн орлогын суурийг өргөжүүлэх, далд эдийн засгийн хэмжээг багасгах, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг өсгөх арга замын талаарх санал, зөвлөмжийг Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлэв. Зөвлөмжийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2026 онд нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс 150 тэрбум төгрөгөөр, тэтгэврийн нөөц санд байршуулсан хөрөнгөнөөс 85 тэрбум төгрөгөөр Засгийн газрын дотоод үнэт цаасыг тус тус худалдан авч, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг эрсдэлгүй найдвартай эх үүсвэрт хөрөнгө оруулж, хүүгийн өгөөжөөр сангийн хөрөнгийг өсгөх боломжийг бүрдүүлэн ажиллаж байгааг мэдээлэв.

Авлигын гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлэхэд Сангийн яам, Үндэсний аудитын газрыг иргэний нэхэмжлэгчээр тогтоох үндэслэлийн судалгааны зөвлөх үйлчилгээ үзүүлэх судалгааны багийг сонгон гэрээ байгуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, мэдээ, мэдээллээр ханган, үйл ажиллагаанд нь хяналт тавьж, хамтран ажиллаж байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 7.3.3.2 дахь “Тусгай сангуудын үйл ажиллагаанд авлигын эрсдэлийн үнэлгээ хийх” арга хэмжээний хүрээнд “Авлигын эрсдэлийн үнэлгээ”-г 2024-2025 онд Эрүүл мэндийг дэмжих сан, Нийгмийн халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд өгсөн зөвлөмжийн ийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийхэд дунджаар 62,0 хувьтай буюу “үр дүн хүлээгдэж байгаа” ангилалд дүгнэгдэв.

• Хөтөлбөрийн Зорилго 8 (Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэн ил тод, үр ашигтай, хариуцлагатай хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.)-ын хүрээнд:

Засгийн газраас төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах, засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдахаар болсонтой холбогдуулан төрийн өмчит хуулийн этгээдийн засаглал, хөрөнгө, санхүүгийн удирдлагатай холбоотой асуудлыг уялдуулан судалж, засаглал, удирдлага,

зохион байгуулалтыг сайжруулах талаарх зөвлөмжийг Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлэв.

- Хөтөлбөрийн Зорилго 9 (Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг олон нийтийн оролцоонд тулгуурлан цогц байдлаар зохион байгуулна.), 9.1.2 Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг үнэлэх арга зүйг боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх зорилтын хүрээнд Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлд заасан олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтэд байгууллага өөрийн үнэлгээ хийх асуумжийн төслийг боловсруулсан.

Зорилт 9.2-т заасан Олон нийтийг авлигаас ангид байлгах, нийгмийн ёс суртахууныг дээшлүүлэх зорилгоор үндэсний контентыг бүтээж, түгээх хүрээнд:

Хүүхэлдэйн театртай хамтран уул уурхайн салбар луу чиглэсэн хүүхэд багачуудыг байгаль эх дэлхийгээ хайрлах, шударга зөв дадал хэвшилд сургах, шударга бус зүйлийн хор хөнөөлийг ойлгуулах агуулга бүхий бага насны хүүхдэд зориулсан “Мөчрөн хуруут охин” хүүхэлдэйн жүжгийн зохиолыг бичиж, жүжгийг бүтээн, туурвих ажлыг эхлүүлсэн бөгөөд ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна. Жүжгийн нээлтийг 2026 оны 9 дүгээр сард хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Зорилт 9.3-т заасан “Ёс суртахуун, хүмүүжлийн ажлын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөрийг олон улсын туршлагад тулгуурлан шинэчлэлт, үнэлгээ хийж хэвшүүлнэ.” арга хэмжээний хүрээнд Боловсролын яам, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнтэй хамтран дараахь ажил, арга хэмжээг хэрэгжүүллээ. Тухайлбал,

- Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн “Бага боловсролын сургалтын хөтөлбөр”-ийн төсөлд шударга ба шударга бус үйлдлийн ялгааг ойлгох, шударга зөв үйлдлийг өөртөө төлөвшүүлэх, шүүн тунгаах, багаар ажиллах, бусдын санаа бодлыг хүндэтгэх зэрэг шударга ёсны агуулгыг тусгах санал хүргүүлснээс холбогдох саналууд хөтөлбөрт тусгагдан Боловсролын сайдын тушаалаар батлагдсан.
- Мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрт шударга ёс, авлигын хор хөнөөлийн талаар тусгуулах санал хүргүүлснээс Мэргэжлийн боловсролын 1 жил, 3 жилийн сургалтын хөтөлбөрийн агуулгад “Хөдөлмөрт бэлтгэх” 54 цагийн чадамжийн нэгжийг судлуулахаар тусгасан байна. Үүнд мэргэжлийн салбарт үүсэж болзошгүй авлигын хэлбэрүүдийг таньж тодорхойлох (Барилгын материалын тооцоо, чанарын зөрчил; Авто засварын үйлчилгээний шударга бус байдал; Санхүүгийн тайланг хуурамчаар бүрдүүлэх г.м), ажлын байранд авлигыг таних, түүнээс татгалзах, “Би шударга мэргэжилтэн” амлалт гарын үсэг зурах зэрэг зан үйлийн төлөвшлийг 100 хувь бүрэн тусгасан байна.
- Их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийн агуулгад мэргэжлийн ёс зүй, шударга ёс, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулгыг тусгах зорилгоор Боловсролын сайдын тушаалаар байгуулагдсан хөтөлбөрийн чанар тогтоох ажлын хэсэг хамтран ажиллаж байна. Одоогоор 11 их, дээд сургууль, коллеж ирүүлсэн судалгаанд дүн шинжилгээ хийгээд байна.
- Боловсролын сайдын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/137 дугаар тушаалаар авлигыг үл тэвчих, шударга ёсны агуулга бүхий “Ёс суртахууны хариуцлага” сургалтыг дэмжих хөтөлбөрийг баталсантай бөгөөд Боловсролын ерөнхий газартай хамтран тус хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх судалгаа авлаа. Судалгаагаар багш нарын 84.7 хувь, нийгмийн ажилтнуудын 77,0 хувь нь зан үйлийн эерэг өөрчлөлт гарсан гэж үзсэн бөгөөд суралцагчдын 93.4 хувь нь шударга байдлыг ёс суртахууны хамгийн гол үнэт зүйл гэж тодорхойлсон байна. Хөтөлбөрийг 2027 онд шинэчлэн ахлах ангийн сургалтын хөтөлбөрт тусгахаар төлөвлөөд байна.

Зорилт 9.4 (Хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулах арга замаар ёс зүйн төлөвшлийг дэмжинэ.)-ийг хэрэгжүүлэх зорилгоор хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсэд судалгаа хийж байна. Судалгааг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын Сургалт, судалгаа, мэдээллийн төвтэй хамтран судалгааны асуулга, аргачлал, удирдамжийг боловсруулсан.

Төлөвлөгөөний дагуу 2026 оны 6, 7 дугаар сард мэдээлэл цуглуулж, 8 дугаар сард мэдээллийг боловсруулан дүн шинжилгээ хийж, 9 дүгээр сард судалгааны тайланг эцэслэн боловсруулах бөгөөд үр дүнг 2026 оны дөрөвдүгээр улиралд олон нийтэд түгээхээр төлөвлөөд байна. Судалгааны үр дүнд хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж буй гол хүчин зүйлс, тэдгээрийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, хүүхдийн ёс зүйн төлөвшил, авлигыг үл тэвчих хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн бодлого, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг судалгааны нотолгоонд тулгуурлан төлөвлөхөд ашиглах боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Ерөнхий боловсролын сургуулиудын “Шударга ёсны клуб”-ын үйл ажиллагааг сурталчлах, клуб хооронд туршлага солилцох үйл ажиллагааг тогтмолжуулах зорилгоор клубийн 2026 оны нэгдсэн төлөвлөгөө, үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлт боловсруулж, клубүүдэд хүргүүлэн, арга зүйн удирдлагаар хангаж ажиллав.

Нийслэлийн ерөнхий боловсролын 1, 12, 32, 40, 84 дүгээр сургууль болон Багануур дүүргийн Цогцолбор сургуулийн “Шударга ёсны клуб”-ийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, зөвлөмж, чиглэл өгч, сурагчдын шударга ёсны талаарх мэдлэг, хандлага, оролцоог үнэлэх судалгаа авлаа.

Зорилт 9.5.2 Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчилна.

Vip76.mn цахим хэлэлцүүлгийн форумтай хамтран шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх, авлигыг мэдээлэх аюулгүй, үр дүнтэй тогтолцоог бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах, авлигатай тэмцэх эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор цахим хэлэлцүүлгийг “Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль”-ийн хэрэгцээ шаардлага, үзэл баримтлал, ач холбогдол, зохицуулалтын талаар 12 экспертийг урьж хэлэлцэв. Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах зорилгоор 2 контент бүтээлээ.

• Хөтөлбөрийн Зорилго 10 “Гамшгаас хамгаалах, онц байдлын үеийн үйл ажиллагаа болон үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаанд авлигаас урьдчилан сэргийлэх тогтолцоо бүрдүүлнэ.” Зорилт 10.2.6 “Гамшгаас хамгаалах болон онц байдлын үед тусгай үүрэг гүйцэтгэн ажиллах байгууллагын авлигын эрсдэлийг тодорхойлж, бэлэн байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.”-ыг хэрэгжүүлэхээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны харьяа гамшгаас хамгаалах улсын албыг үнэлгээнд хамруулахаар сонгон эрсдэлийн үнэлгээг хийж байна. Ажлын гүйцэтгэл 50 хувьтай бөгөөд үнэлгээний ажил үргэлжилж байна.

Зорилт 10.2.3 “Гамшгаас хамгаалах болон онц байдлын үеийн хандив, тусламжийг бүртгэх, зарцуулалтыг ил тод болгох, хяналт тавих олон нийтэд нээлттэй цахим системийг нэвтрүүлнэ.”-ийг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Шадар сайдын Ажлын албатай уулзалт зохион байгуулсны дээр Сангийн яамтай зөвшилцөж шийдвэрлэхээр тохиролцов.

Зорилт 10.3 “Ирээдүйд тулгарч болзошгүй нөхцөл байдлын үеийн авлигын эрсдэлийг тооцоолон хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, учирч болох хор хохирлоос урьдчилан сэргийлнэ.”-ийг хэрэгжүүлэхээр “Ирээдүйд тулгарч болзошгүй авлигын эрсдэл бүхий нөхцөл байдлыг тодорхойлох, үнэлэх аргачлал боловсруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан шаардлагатай мэдээлэл, арга зүйн зөвлөгөөгөөр ханган, хяналт тавин хамтран ажиллаж байна.

Гурав. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын талаар:

3.1 Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх хэсэгт заасан “улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих” чиг үүргийн хүрээнд дараах ажил арга хэмжээг хэрэгжүүллээ.

ХЗДХЯ-ны дэргэдэх Нээлттэй мэдээллийн ил тод байдлын орон тооны бус зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон Засгийн газарт хүргүүлэх зөвлөмжийн төсөлд

санал хүргүүлэв. Тус зөвлөлийн гишүүдэд "Шударга байдлын үнэлгээ"-ний үр дүнг танилцуулах ажлыг зохион байгууллаа.

Нийслэлийн 1, 12, 32, 40, 84 болон Багануур дүүргийн "Цогцолбор" сургуулийн "Шударга ёсны клуб"-ийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж зөвлөмж өгөхийн зэрэгцээ нийслэлийн 12 дугаар сургуулийн 1905 сурагчийг хамруулсан нөлөөллийн ажил, 1130 сурагчийн оролцоотой гоёл уралдааныг зохион байгуулсан нь үр дүнтэй ажил боллоо.

3.2 Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь хэсэгт заасан "авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах талаар аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлд үүрэг, чиглэл өгөх;" чиг үүргийн хүрээнд:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөлийн болон Нийслэл дэх салбар зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд холбогдох саналыг хүргүүлж, тус төлөвлөгөөнд тусгагдсан Авлигатай тэмцэх газрын чиг үүрэгт хамаарах ажил, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж, тайланг хүргүүлэв.

Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журмын 2024, 2025 оны гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх чиглэл тодорхойлох, хяналт хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах, тэдгээрийг чадавхжуулах, шаардлагатай зардлын эх үүсвэрийг шийдвэрлүүлэх зэрэг асуудлаар уулзалт, хэлэлцүүлэг хийж, нийслэлийн 9 дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба болон Засаг даргын Тамгын газрын 33 ажилтныг чадавхжуулах сургалтад хамруулав.

3.3 Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх хэсэгт заасан "төрийн бус байгууллага, иргэдээс авлигатай тэмцэх талаар явуулж байгаа үйл ажиллагаа, гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах, тэдний оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;" чиг үүргийн хүрээнд авлигын эсрэг хууль тогтоомж болон Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэн, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж байна. Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Сагсан бөмбөгийн холбоо, Мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Монголын хуульчдын холбоо, Уул уурхайн үндэсний ассоциаци, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг ТББ, Монголын сурагчдын холбоо ТББ, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, Монгол Улсын спортын мэргэжлийн холбоод зэрэг 14 төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллалаа. Тухайлбал, Монголын ажил олгогч эздийн холбоо" ТББ-тай авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр "Хамтын ажиллагааны санамж бичиг" байгуулав. Энэхүү Санамж бичгийн хүрээнд талууд төлөвлөгөө батлан хэрэгжүүлж байна. Барилгын салбарын мэргэжлийн холбоод, салбарын аж ахуйн нэгж байгууллагын 30 гаруй төлөөлөл, мөн аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын мэргэжлийн холбоод, салбарын аж ахуйн нэгж байгууллагын 25 төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, зөвлөмж гаргалаа.

"Монголын сагсан бөмбөгийн холбоо" ТББ, "Монголын волейболын холбоо" ТББ-тай спорт дахь авлига, шударга бус шүүлт, тоглолт наймаалцахаас урьдчилан сэргийлэх, тамирчид, дасгалжуулагч, шүүгчдийн шударга ёсны талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, багийн спортоор дамжуулан хүүхэд залууст шударга ёсны үзэл дэдлэг төлөвшүүлэх чиглэлээр "Хамтын ажиллагааны санамж бичиг"-ийг тус тус байгууллаа. Эдгээр холбоодтой хамтран богино хэмжээний контент бүтээх, тэмцээний үеэр шударга ёс, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилсан сэргийлэх агуулга бүхий контент нэвтрүүлэх, сургалт хийх, хүүхэд багачуудын дунд гар зургийн уралдаан зарлаж бүтээлийг шалгаруулах зэрэг арга хэмжээг зохион байгууллаа.

Монголын Хуульчдын холбоо ТББ-аас жил бүр зохион байгуулдаг "Хуульчийн пробон", "Өмгөөлөгч танд тусалъя" өдөрлөгт хамтран оролцож, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэл, энэ талаарх гомдол, мэдээлэл гаргах, хүлээн авах, эрх зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулан, сурталчилгааны материал түгээв.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, “Номын соёлт ертөнц” ТББ-тай хамтран авлигын эсрэг соён гэгээрүүлэх цогц арга хэмжээг зохион байгууллаа. АТГ-аас сүүлийн 20 жилд (2006–2026) гаргасан 36 нэр төрлийн ном, гарын авлагаар QR код бүхий цахим номын сан үүсгэснийг танилцуулж, сурталчилгааны материалыг түгээн, 350 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгсөн.

3.4 Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.2 дахь хэсэгт заасан “авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах” чиг үүргийг хангах хүрээнд: 2026 оны 03 дугаар сараас “Тус солишн” ХХК-ийн компанийн хөгжүүлсэн tuss.io хиймэл оюун ухаант (AI) платформыг төрийн албаны ил тод байдал, хүнд суртал чирэгдэл учруулахгүй байх, авлигын эрсдэлийг бууруулах зорилгоор үйл ажиллагаанд нэвтрүүлэн, ашиглаж байна.

Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны А/183 дугаар “Заавар батлах тухай” тушаалаар баталсан “Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, дүрэм, журмыг хянах заавар”-ын дагуу tuss.io хиймэл оюун ухаант (AI) платформыг ашиглан нийт 8 салбар (санхүү салбарын 33, Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын 17, хууль зүйн салбарын 4, эрүүл мэндийн салбарын 2, зам тээвэр, уул, уурхай, барилгын салбарын 3, төрийн өмчит хуулийн этгээд)-т хамаарах 67 шийдвэр, дүрэм, журам, гэрээг хянаж, дүрэм, журмыг бүхэлд нь хүчингүй болгох, хуульд заасан шаардлага хангуулах саналыг хүргүүлснээс эрх бүхий байгууллагаас 9 дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулж, 9 актыг хүчингүй болсонд тооцсон бөгөөд 49 дүрэм, журмыг хянаж байна.

Санал хүргүүлснээр хүчингүй болсон акт, гэрээнээс дурдвал:

- Нийслэлийн Засаг даргын 2026 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн “Мопед (скүүтер болон түүнтэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэл)-ыг нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд хязгаарлалтайгаар оролцуулах тухай” А/387 дугаартай захирамж, 2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” А/552 дугаартай захирамжийг хянаж, эрх бүхий албан тушаалтнууд хуулиар олгоогүй эрхийг хэрэгжүүлсэн гэж үзэж хуульд заасныг үндэслэн шаардлага хүргүүлснээр Нийслэлийн Засаг даргын 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/820 дугаартай захирамжаар дээрх 2 захирамжийг хүчингүй болгон шийдвэрлэлээ.
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2025 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн А/274 дүгээр тушаалаар “Эс Би Би Эвер Инвестмент” ХХК-д Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Сөүлийн гудамж, Улсын Драммын Эрдмийн Театр (УДЭТ)-ын дэргэд гадна зар сурталчилгааны тулгуурт байгууламжийн зөвшөөрлийг олгосон шийдвэр, гэрээг хянаж, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн авлигын эрсдэлтэй шийдвэр гэж үзэн шаардлага хүргүүлснээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн А/156 дугаар тушаалаар тухайн зөвшөөрөл, 2025 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн А/274 дугаартай тушаал, гэрээг хүчингүй болгосон.
- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн “Журам батлах тухай” 4/27 дугаар тогтоол “Нийтийн эзэмшлийн зам талбайд тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоол ажиллуулах журам”, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2011 оны “Журамд өөрчлөлт оруулах тухай” 7/66 дугаар тогтоолыг тус тус хянаж, давхцал бий болсон, авлига, ашиг зөрчил үүсгэх эрсдэлтэй үзэж шаардлага хүргүүлснээр дээрх 2 журмыг хүчингүй болсонд тооцсон зэрэг болно.

Авлигын эсрэг хуулийн 6.1.9 дэх хэсэгт “Төрийн байгууллага тухайн салбарын албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлан гаргахын өмнө Авлигатай тэмцэх газраас санал авах” гэж заасны дагуу 1 ёс зүйн дүрмийн төсөлд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон холбогдох бусад хэм хэмжээг тусгах талаар санал хүргүүллээ.

3.5 Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь хэсэгт заасан “Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг

зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх” чиг үүргийн хүрээнд дараах ажил, арга хэмжээг зохион байгуулав. Үүнд:

2026 оны эхний хагас жилийн байдлаар авлигын хор аюулыг ухуулан таниулах, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор төрийн байгууллагад 292 удаагийн сургалтад 24980 хүнийг, үүнээс төрийн байгууллагад 203 сургалтаар 16464 хүнийг, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 32 удаагийн сургалтад 2240 хүнийг, хувийн хэвшлийн байгууллагад 34 удаагийн сургалтад 4288 хүнийг, төрийн бус байгууллагад 13 удаагийн сургалтыг зохион байгуулж 663 хүнийг, боловсролын салбарын буюу оюутан, залуус, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан 10 удаагийн сургалтад 1325 хүнийг хамран суралцуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал, сургалтад хамрагдсан хүний тоо 8973 нэгжээр буюу 56,0 хувиар, түүний дотор хувийн хэвшлийн ажилтнуудад чиглэсэн сургалтад хамрагдсан хүний тоо 1 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах үйл ажиллагаандаа татан оролцуулах зорилгоор сургагч багш бэлтгэх сургалтыг төрийн байгууллагын 31 албан хаагчийг хамруулан зохион байгуулж, гэрчилгээ олголоо. Сургагч багш нарын дунд цахимаар холбоос үүсгэн мэдээлэл, арга зүйн зөвлөгөө дэмжлэгийг тогтмол өгч хамтран ажиллаж байна.

Сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх, албан хаагчдын ачааллыг бууруулах зорилгоор Пүрэв гараг бүрийн 10 цагт цахим нэгдсэн сургалт хийдэг “4/10 хөтөлбөр”-ийг шинээр эхлүүлэв. Тус хөтөлбөрийн хүрээнд 9 удаагийн сургалтаар 1940 хүнийг цахим сургалтад хамруулж, Zoom эрхийн давхардлыг арилгалаа.

Moodle платформд суурилсан “Авлигын ойлголт” цахим сургалтыг боловсруулж, видео хичээл, HP5 интерактив дасгал, тест, хэлэлцүүлэг болон цахим батламж цахим сургалтын платформыг хөгжүүлж байна. Энэ хүрээнд Авлигын ойлголт, Авлигын шалтгаан нөхцөл хор хөнөөл гэсэн 2 модулийг бэлтгэж дууссан, засваруудыг хийж байна.

Үндэсний аудитын газар, Голомт банк, ЦЕГ-тай хамтран “Авлигын ойлголт” сэдэвт 6 модулийг бэлтгэн тус байгууллагын дотоод сургалтад ашиглах нөхцөлийг бүрдүүллээ.

Соён гэгээрүүлэх ажлын үр дүн үнэлэх аргачлалыг нэвтрүүлэх арга хэмжээ авахаар сургалтын үнэлгээний хуудсаар судалгаа авч хэвшээд байна. Нийт сургалтад хамрагдсан хүний 43.0 хувь нь судалгаанд хамрагдсанаас 96,2 хувь нь шинэ мэдлэг, ойлголтыг авсан, 95,5 хувь нь сургалтын агуулга, хэлбэрийг оновчтой, 98,0 хувь нь сургалтад ашиглаж буй слайд, жишээг ойлгомжтой гэж үзсэн бол сургалт хийсэн багшийн ур чадварыг 93,6 хувь нь хангалттай гэж үнэлжээ. 2026 оны эхний хагас жилийн байдлаар сургалтад хамрагдсан оролцогчдоос нийт 2,698 сэтгэгдэл, санал хүсэлт ирсэн байх бөгөөд дийлэнх хувь нь сургалтад сэтгэл өндөр байгаагаа илэрхийлсэн байна.

“Санхүү, бизнесийн эрх зүйн судалгааны хүрээлэн” НҮТББ-тай хамтран “Авлигын криминологи” сургалтын хөтөлбөрийг боловсруулж, туршилт сургалтыг Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа байгууллагын 40 ахлах хуульчийг хамруулан зохион байгууллаа.

Хууль зүйн салбарын оюутан залуусын онолын мэдлэгийг практиктай холбох, мэтгэлцэх ур чадварыг хөгжүүлэх зорилготой “Mock Trial-2026” эрүүгийн хэргийн шүүхийн мэтгэлцээний тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд Монгол Улсын Их сургууль, Глобал удирдагч Их сургууль, Зохиомж их сургууль, Олон улсын Улаанбаатарын Их сургууль, Рояаль Олон Улсын Их сургууль, СИТИ Их сургууль, Их засаг Их сургууль, Чингис соосэ Олон улсын харилцааны Их сургууль, Отгонтэнгэр Их сургууль, Санхүү Эдийн засгийн Их сургууль, Шихихутуг Их сургууль, Дотоод хэргийн их сургууль буюу хуулийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг 11 их сургуулийн 19 багийн 120 гаруй оюутан, 14 багш оролцож, шилдгүүдийг шалгарууллаа.

Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, Зэвсэгт хүний жанжин штаб, Үндэсний батлах хамгаалахын Их сургууль, Монголын сурагчдын холбоо хамтран 2026 оны 3 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдсан ерөнхий боловсролын сургуулиудад хэрэгжүүлэх “Монгол улсын Төрийн далбаа мандуулах хөтөлбөр”-ийн нээлтийн арга хэмжээний хүрээнд “Шударга ёсны андгай өргөх арга хэмжээ”-г хариуцан зохион байгуулав. Тус арга хэмжээнд нийслэлийн төрийн өмчийн 167 сургуулийн захирал, нийгмийн ажилтан болон сурагч, эцэг эхийн төлөөлөл бүхий нийт 1670 хүн хамрагдав.

Нийслэлийн бүх ЕБС-ийн 6-12 дугаар ангийн сурагчид долоо хоног бүрийн Даваа гарагт хичээл эхлэхийн өмнө андгай уншиж хэвшээд байна.

“Хүүхэд-хүүхдэдээ” зарчмаар үе тэнгийнхэндээ шударга ёсны ойлголтыг түгээх “333 сургагч багш” төслийн сургалтын хөтөлбөрт шударга ёсны агуулгыг тусгуулахаар хамтран ажиллаж байна.

Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлын хүрээнд Мобиком корпорацтай хамтран Авлигатай тэмцэх газраас эрхлэн гаргасан авлигын эсрэг сэдэвчилсэн кино, контентуудыг OTT /over-the-top/ технологид суурилсан VOO платформаар дамжуулан олон нийтэд үнэ төлбөргүй түгээх ажлыг эхлүүлж, 12ш контентыг тус санд байршуулав.

Зуслангийн хөтөлбөрөөр дамжуулж хүүхдэд шударга ёсыг ойлгуулах “Бүлгийн удирдагчийн гарын авлага”, “Нийтийн албан тушаалтанд зориулсан халаасны гарын авлага”, “Оюутан залууст зориулсан гарын авлага”-ыг боловсруулж байна. Байгууллагаас сүүлийн 20 жил (2006–2026)-ийн хугацаанд бүтээсэн, хэвлүүлсэн 36 төрлийн ном, гарын авлагыг цахимжуулж, QR код бүхий цахим номын сан үүсгэсэн ба “Уламжлал” сэтгүүлд 2 төрлийн мэдээг нийтлүүлэв.

Монголын сургуулиас гадуурх сургалтын “Санрайс холбоо” ТББ-тай хамтран нийслэлийн ерөнхий боловсролын 21, 23, 52 дугаар сургуулийн 8-11 дүгээр ангийн 60 сурагчийг “Өсвөр үеийнхний хөгжил, төлөвшил” соён гэгээрүүлэх сургалт, өдөрлөг, Монголын Үндэсний олимпын хороо, Биеийн тамир, спортын хороотой хамтран буудлага, бокс, хөнгөн атлетик, пара жүдо, шатар, ширээний теннис, хүндийн өргөлтийн үндэсний шигшээ багийн 112 тамирчин, дасгалжуулагчдын дунд “Шударгаар өрсөлдье” соён гэгээрүүлэх арга хэмжээ, Монголын Үндэсний зуслангуудын холбоо болон “Найрамдал” цогцолбортой хамтран хүүхэд, өсвөр үеийнхний дунд шударга ёсны үзэл хандлагыг төлөвшүүлэх зорилгоор 21 аймаг, нийслэлийн хүүхдийн зуслангуудын захирал, менежер, бүлгийн удирдагч, арга зүйч 142 төлөөлөгчийг хамруулан “Шударга ёсны боловсрол” өртөө, Налайх дүүрэгт 42 байгууллагын 131 төрийн албан хаагч, иргэд, олон нийтийн 139 төлөөлөл, нийт 270 хүнийг хамруулсан “Авлигаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт өдөрлөг, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран тус дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын 300 гаруй албан хаагчдыг оролцуулан “Бид-авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид хамт олон” аян, “Зорчигч тээвэр хоёр” ОНӨААТҮГ-тай хамтран “Авлигын эсрэг соёлыг түгээе” аян зэрэг соён гэгээрүүлэх ажил арга хэмжээг зохион байгууллаа.

Радиогийн нэвтрүүлгээр дамжуулан иргэдийн авлигын эсрэг мэдлэг, мэдээллийг дээшлүүлж, иргэдийн оролцоог хангаж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын хор хөнөөлийг танин мэдүүлэх зорилгоор “Авто радио 96,3”-тай хамтран “5 асуулт” видео подкастын 4 аудио, 4 видео дугаарыг бэлтгэн олон нийтийн хүртээл болголоо.

Аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран авлигын хор хөнөөлийг ухуулан таниулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулга бүхий богино хэмжээтэй 25 Reel видео бүтээж, төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллагуудын цахим хуудас, Авлигатай тэмцэх газрын “Олон нийтийн төв” пейж хуудас болон бусад олон дагагчтай пейж хуудсуудаар олон нийтэд түгээв. Монголын Үндэсний олимпын хороо, Биеийн тамир, спортын хороотой хамтран хоккей, жүдо, чөлөөт бөх, пара байт харваа, пара таеквондо зэрэг спортын мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулан авлигын эсрэг контентод оролцуулаа. “11-10” тусгай дугаарын сурталчилгааг Нийслэлийн авто тээврийн бүртгэл, хяналтын төвтэй хамтран “Нисдэг машин”, “Хан-Уул төв”-ийн цахим самбаруудаар видео шторк түгээж, E-Mongolia, Viber Ads-аар дамжуулан хийсэн нь үр дүнтэй боллоо.

“Авлигатай тэмцэх газар” болон “АТГ-Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс” фейсбүүк хуудсаар авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 4 подкаст, 59 пост мэдээлэл, 26 рийл видео, 11-10 дугаарын сурталчилгааны 3 шторк, контент бэлтгэж нийтлэв. Фейсбүүк дэх хандалт болон пост мэдээний хүртээмж өмнөх жилийн өмнөх үеэс эрс өсч, 617,939 хүнд хүрч, 13,456 удаагийн лайк, шэйр хийгдсэн дүнтэй байна. Байгууллагын Instagram хуудасны дагагчдын тоо тогтвортой өсч 5,600 болж, органик хандалт нэмэгдсэн

бөгөөд үндсэн дагагчдын дийлэнх хувийг Улаанбаатар хотын 35-44 насны зорилтот бүлэг эзэлж байна.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах зорилгоор “Авлигатай тэмцэх газар хэрхэн гомдол, мэдээлэл гаргах вэ”, “Иргэн та авлигын эсрэг юу хийж чадах вэ” брошюр, нийтийн албан тушаалтны хуулиар тогтоосон 14 төрлийн хориглолт, хязгаарлалтыг сурталчилсан нугалбар буюу 3 төрлийн тараах материалыг хэвлүүлэн нийтийн хүртээл болголоо.

3.6 Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь хэсэгт заасан “авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар зөвлөмж гаргах, байгууллага, иргэний хүсэлтээр түүний үйл ажиллагаан дахь авлигад өртөх боломжийг багасгах талаар заавар, зөвлөгөө өгөх” чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлэв.

Авлигын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын шалтгаан нөхцөл, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг арилгах, төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй үзүүлэх, авлигын эрсдэлийг бууруулах чиглэлээр 5 байгууллагад зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Үүнд: Нийслэлийн ИТХ-ын дарга, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сүхбаатар дүүргийн болон бусад дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн болно.

Эрх бүхий байгууллага, албан тушаалтанд 2025 онд хүргүүлсэн 32 зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, авлигын эрсдэлийг тогтоох, шалтгаан, нөхцөлийг арилгах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, хүнд суртал чирэгдлийг бууруулах чиглэлээр 6 байгууллага, албан тушаалтанд шаардлага хүргүүлээ.

Дүн шинжилгээгээр хангалттай сайн хэрэгжүүлсэн буюу зөвлөмжийн 80-100 хувь хэрэгжүүлсэн 15, дундаж буюу анхаарах шаардлагатай (60-80 хувь) 11, эрсдэлтэй буюу хэрэгжилт хангалтгүй (0-60 хувь) 5, хэрэгжилт хүлээгдэж байгаа 1 байгууллага байлаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу авлигын гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, авлигаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авхуулахаар хүргүүлсэн мөрдөгчийн 51 мэдэгдэл, 24 албан бичгийн, үүнээс 34 мэдэгдлийн мөрөөр газар дээр нь ажиллаж, хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, зөрчлийг арилгах, давтан гаргуулахгүй байхад чиглэсэн зөвлөмж хүргүүлэх, мэдээлэл арга зүйгээр хангах, сургалт хийх, авлигын эсрэг сурталчилгааны материал түгээх зэргээр хамтран ажиллаж байна.

3.7 Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12-т заасны дагуу авлигын эрсдэл, шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг арилгах арга хэмжээ авах хүрээнд 2025 онд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд нийт хүргүүлсэн 32 зөвлөмжийн 17 (53.1 хувь) нь үр дүнтэй буюу бүрэн хэрэгжсэн, 8 (25.0 хувь) нь хангалтгүй буюу бүрэн хэрэгжээгүй, 7 нь (11 хувь) хүлээгдэж байна. Тайлант хугацаанд 5 байгууллагад зөвлөмж, 6 байгууллагад шаардлага хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Дөрөв. Судалгаа, шинжилгээний ажлын чиглэлээр:

Авлигын эсрэг хуульд заасан чиг үүрэг, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан бодлогын болон зорилтот судалгааны ажлуудыг гүйцэтгэхийн зэрэгцээ Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т заасныг үндэслэн авлигын асуудлаар эрдэм шинжилгээний судалгаа хийхэд төрийн бус байгууллагуудыг оролцуулах зорилгоор зарим судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна. 2026 оны эхний хагас жилийн байдлаар:

- Уул уурхайн салбарын авлигын эрсдэлийн үнэлгээ хийх хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газрын тусгай зөвшөөрөл олголт, шийдвэр гаргах үйл явц, дотоод хяналтын тогтолцоонд иж бүрэн үнэлгээ хийв. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын, бичил уурхай эрхлэх, түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах зэрэг зөвшөөрлүүдийг үнэлгээний объект болгон сонгож, санал,

зөвлөмж бүхий тайлангийн төслийг боловсруулсан бөгөөд ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна

• “Шударга байдлын үнэлгээний сүүлийн 10 жилийн хугацаанд хийгдсэн 9 удаагийн судалгааны тайлангийн мэдээллийг нэгтгэн, яам, агентлаг, аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар гэсэн 4 ангиллын нийт 81 байгууллагыг үр дүнгээр нь эрэмбэллээ. Ангилал тус бүрээс хамгийн бага үнэлгээтэй 5 байгууллагыг сонгон, 16 дэд үзүүлэлтээр задлан шинжилж, дүгнэлт, зөвлөмж бүхий тайлангийн төслийг боловсруулаад байна. Ажлын гүйцэтгэл 80 хувьтай үргэлжилж байна.

• Худалдан авах ажиллагааны авлигын нөхцөл байдлын судалгааны хүрээнд 2024–2025 онд зохион байгуулсан тендер шалгаруулалтын мэдээлэл (захиалагч, зарласан болон дахин зарласан тендерийн тоо, төсөвт өртөг, шалтгаан нөхцөл)-д дүн шинжилгээ хийж, тендер шалгаруулалтын үе шат бүрд үүсэж болзошгүй авлигын эрсдэлийг тодорхойлох ажиллагаа хийгдэж байна. Ажлын явц 50 хувийн гүйцэтгэлтэй байна.

• “Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа”-г 2025 онд “Хөгжлийн санаачлага, бодлого судлалын төв” НҮТББ-тай гэрээ байгуулж, гүйцэтгэгчдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч үйл ажиллагаанд нь хяналт тавин ажилласан. Авлигын шалтгаан нөхцөл, цар хүрээ, үр дагавар, хэлбэр болон эдгээртэй холбоотой олон тооны үзүүлэлтийг тооцоолох, хэмжих, өмнөх онуудын судалгааны үр дүнтэй харьцуулан авлигатай тэмцэх бодлогыг боловсруулахад ашиглах, авлигатай тэмцэх арга замыг тодорхойлох зорилгоор “Модун хөгжлийн төв” НҮТББ-тай хамтран “Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдлын судалгаа”-г хийсэн. Энэхүү 2 судалгааны тайланд дүн шинжилгээ хийж, судалгаанд суурилсан урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх болон бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүллээ.

• Авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх агуулга, сэдвийг тусгасан сургалтын агуулга, хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, үр нөлөөг үнэлэхээр ажиллаж байна. Боловсролын яамтай хамтран, 2023 онд их, дээд сургуулиудад хүргүүлсэн “Авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх агуулга бүхий сургалтыг сургалтын хөтөлбөрт тусгах” зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх, цаашдын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Ажлын хэсгээс их, дээд сургуулиудад сургалтын хөтөлбөрт дээрх агуулгыг тусгасан байдал, хэрэгжилтийн түвшинд хяналт үнэлгээ хийж, сургалтад хамрагдсан оюутнуудаас мэдлэг, хандлага, ёс зүйн төлөвшилд үзүүлсэн үр нөлөөг тодорхойлох судалгааг авлаа. Төлөвлөсөн ажлын хэрэгжилт 50 хувьтай байна.

Тав. Хяналт шалгалт, дүн шинжилгээний ажлын талаар:

5.1 Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан талаар:

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 9603 этгээдийн ХАСУМ-ийг хүлээн авч, өмнөх оны үлдэгдэл 327, нийт 9862 этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянан шийдвэрлэж, холбогдох байгууллагад хариуг хүргүүлсэн бөгөөд ажиллагааны үлдэгдэл 68 байна.

Хүснэгт 1 Хянан шалгасан хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)

		Нийт хянавал зохих	Хянасан	Үүнээс:				Үлдэгдэл
				Ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй	Ашиг сонирхлын зөрчил нөхцөл байдлыг анхааруулсан	Илт ашиг сонирхлын зөрчил үүсэх	Хуульд зааснаар буцаасан	
2025	эхний хагас жил	12651	12458	11121	957	52/0.4%	328 /2.6%	193 /1.5%
2026		9862	9794	9162	904	87/0,9%	613	68/0,7%

Нийтийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн 87 этгээд тухайн албан тушаалд томилогдоход илт ашиг сонирхлын зөрчилтэй нь тогтоогдсон тул томилох эрх бүхий албан

тушаалтанд мэдэгдсэн, үүнээс 11 нэр дэвшигч хяналтаар тогтоосон зөрчлийг арилгасан дахин хянуулснаар албан тушаалд томилогдсон байна.

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг хянуулалгүй томилсон 8 албан тушаалтанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т заасны дагуу албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах арга хэмжээг авахуулахаар томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлснээс 3 албан тушаалтныг албан тушаалаас нь чөлөөлж, 4 албан тушаалтанд хариуцлага тооцуулаад байна.


5.2 Мэдүүлгийн бүрдүүлэлтийн талаар-Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын 2025 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийг шинэчлэн бүртгэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасныг үндэслэн ХАСХОМ-ийн талаарх нэгдсэн дүн мэдээг гаргалаа.

ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлэх хуулийн хугацаанд буюу 2025 оны 02 дугаар сарын 15-ны дотор улсын хэмжээнд нийт төрийн болон нутгийн захиргааны нийт 131 байгууллагын 50236 (цахим-46760, хэвлэмэл байдлаар-3480) мэдүүлэг гаргагч мэдүүлгээ хуулийн хугацаанд мэдүүлж, баталгаажуулсан. Нэр бүхий 4 албан тушаалтан мэдүүлгээ хугацаа хожимдуулж мэдүүлсэн.

Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлэх үүрэгтэй төрийн өндөр болон түүнтэй адилтгах 218 албан тушаалтнаас 216 албан тушаалтан буюу 100 хувь хуулийн хугацаанд шинэчлэн мэдүүлсэн байна. (2 албан тушаалын орон тоо сул байсан.)

Мэдүүлэг гаргагчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1399 нэгжээр нэмэгдсэн байх бөгөөд нийт мэдүүлэг гаргагчдын 12368 буюу 24.6 хувь нь төрийн захиргааны, 16254 буюу 32.4 хувь нь төрийн тусгай, 7960 буюу 15.8 хувь нь улс төрийн, 7556 буюу 15.0 хувь нь төрийн үйлчилгээний удирдах, 276 буюу 0.5 хувь нь төрийн өндөр албан тушаалтан, тэдгээртэй адилтгах, 5826 буюу 11.6 хувь нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон бусад албан тушаалтнууд эзэлж байна.

Дүрслэл 1 ХАСХОМ мэдүүлсэн албан тушаалтан
(төрийн албан тушаалын ангиллаар, өмнөх онтой харьцуулснаар)



Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн тайлан, мэдээнээс үзэхэд 1435 албан тушаалтан “хөрөнгө, орлогын их хэмжээний өөрчлөлт”-ийн талаар мэдүүлж, 1798 албан тушаалтан “ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл” гаргасан бүртгэлтэй байна.

Авлигатай тэмцэх газрын мэдүүлэг гаргагчдын шинэчлэн мэдүүлсэн 2025 оны ХАСХОМ-ийг холбогдох бусад баримтын хамт УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлээ.

Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, 14.3-т заасан үндэслэл болон төрийн албаны ил тод байдал, төрийн албан хаагчийн хариуцлагатай, шударга байдлыг хангах, олон нийт мэдээлэл авах боломжийг олгох зорилгоор Төрийн болон нутгийн захиргааны албан тушаалтны 2025 оны ХОМ-ийн хураангуйг <http://www.xacxom.iaac.mn> цахим хуудсанд 2026 оны 06 дугаар сарын 30-ний өдөр нээлттэй байршуулахад бэлэн болгоод байна.

5.3 Сургалт сурталчилгаа, мэдээлэл арга зүйн ажлын талаар-Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн албан тушаалтны үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, гаргаж байгаа нийтлэг зөрчил, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, ХАСХОМ-ийн шинэчлэгдсэн системийн ашиглах, ХАСУМ-ийг цахимаар мэдүүлэх зэрэг чиглэлээр мэдүүлгийг бүртгэж хадгалах эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ)-ыг мэргэшүүлэх, сурган дадлагажуулах, үйл ажиллагаанд нь тавих хяналтыг дээшлүүлэх, удирдах албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүргийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр сургалт, мэдээлэл, арга зүйгээр хангах ажлыг тасралтгүй зохион байгуулж байна. Мөн видео зааварчилга, гарын авлагыг цахим хэлбэрээр бэлтгэн системд байршуулж тогтмол ашиглах нөхцөлийг бүрдүүллээ.

Тайлант хугацаанд 7 удаагийн удаагийн сургалт (цахим)-д 1500 ЭБАТ, 21 (цахим, танхимаар) удаагийн сургалтад нийт 5141 мэдүүлэг гаргагчийг хамрууллаа.

Дүрслэл 2 Сургалтад хамруулсан албан тушаалтны тоон үзүүлэлт
(өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал)



Мэдүүлэг гаргагч албан тушаалтан нь хуулийн хугацаанд хөрөнгө, орлогын мэдүүлгээ үнэн зөв мэдүүлэх үүргийн талаар телевиз, сонин болон цахим хуудас, болон олон нийтийн мэдээллийн бусад хэрэгсэл, нийтийн сүлжээгээр дамжуулан сурталчилгааг тогтмол хийж мэдээ, мэдээллээр хангаж ажиллалаа.


“Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд зориулсан гарын авлага”, “Мэдүүлэг гаргагч нарт зориулсан гарын авлага”-ыг шинэчлэн хэвлүүлж, төрийн болон нутгийн захиргааны нийт 500 байгууллага, 1500 гаруй ЭБАТ, 5000 орчим мэдүүлэг гаргагчид хүргүүлэв.

5.4 Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийн хяналт, шалгалтын ажлын талаар-2026 оны эхний хагас жилд шинээр хүлээн авсан 86, өмнөх оны үлдэгдэл 15, нийт 101 албан тушаалтны ХАСХОМ-ийг хянан шалгахад 95-г хянан шийдвэрлэж, одоо 6 мэдүүлгийг хянан шалгах ажил үргэлжилж байна.

Хянан шийдвэрлэсэн 95 мэдүүлгийн 54 буюу 56,8 хувийг төлөвлөгөөт хяналт шалгалтаар, 15 буюу 15,8 хувийг иргэдээс гаргасан гомдол, мэдээллийн мөрөөр, 26 буюу 27,3 хувийг бусад хэлтэс, албадаас шилжүүлснээр хянан шалгасан байна.

“Эрсдэлд тооцох аргачлал”-ын хүрээнд мэдүүлгийн “Орлого хэсэгт” өөрийн болон гэр бүлийн гишүүдийн үйл ажиллагааны орлого нь 500,000,000 төгрөгөөс дээш орлого олсон гэж мэдүүлсэн нийт 205, Санхүүгийн зохицуулах хорооны 101, нийт 306 мэдүүлэг гаргагчийн орлого, хөрөнгийн өсөлт, бууралтад цахим систем ашиглан харьцуулсан судалгааг хийж эрсдэлийг тооцон, төлөвлөгөөт хяналт шалгалтад 54 мэдүүлэг гаргагчийг хамруулан хяналт шалгалтыг зохион байгууллаа.

Дүрслэл 3 Мэдүүлгийн хяналт шалгалтын тоон үзүүлэлт
(өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал)



Хяналт шалгалтаар нийт 29, үүнээс Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8.1-д зааснаар 1 мэдүүлэг гаргагчид сануулах, 13.8.2-т зааснаар 7 мэдүүлэг гаргагчид албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, 13.8.3-т зааснаар 15 мэдүүлэг гаргагчид албан тушаалын цалингийн хэмжээг тодорхой хугацаагаар тодорхой хувиар бууруулах, 6 мэдүүлэг гаргагчид 13.8.4-т зааснаар ажлаас халах сахилгын хариуцлага тооцуулсан байна.

Хүснэгт 2 ХАСХОМ-ийн хяналт шалгалт
(өмнөх оны мөн үетэй харьцуулбал)

Хамаарах хугацаа		ХАСХОМ					Хариуцлага тооцуулах үндэслэлтэй	Хариуцлага тооцсон
		Өмнөх оны үлдэгдэл	Хүлээж авсан	Шалгавал зохих	Хянан шийдвэрлэсэн	Үлдэгдэл		
2025	Эхний хагас жил	23	37	60	51	9	8 /15,7%/	8
2026		15	86	101	95	6	29 /30.5%/	29

Хяналт шалгалтаар 18 мэдүүлэг гаргагчийн мэдүүлэгтэй холбогдуулан Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй үйлдэл, мэдээллийг шалгуулахаар тус газрын харьяалах хэлтэст шилжүүлсэн байна.

Албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг шалгахдаа зөвхөн тухайн албан тушаалтны өөрийн болон гэр бүлийн гишүүний өмчлөлд бүртгэлтэй эд хөрөнгийн байдлаар хязгаарлалгүйгээр тэдгээрийн хамаарал бүхий этгээдүүдийн эд хөрөнгө, орлогын эх үүсвэрийг нягтлах замаар нуугдмал эд хөрөнгийг илрүүлэх, мөн ХОМ-т мэдүүлсэн орлогууд нь татварын тайлан, мэдээтэй нийцэж байгаа эсэх, татвараас зайлсхийсэн үндэслэл байгаа эсэхийг тогтоохоор Татварын байгууллага болон бусад эрх бүхий байгууллагатай хамтран ажиллалаа.

Энэ хүрээнд хийсэн хяналт шалгалтаар, өөрийн болон гэр бүлийн гишүүдийн татвар ногдуулах орлогоо үнэн зөв тайлагнаагүй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тул Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар 13 мэдүүлэг гаргагчид холбогдох мэдээллийг Татварын ерөнхий газарт шилжүүлснээр шалгалтаар нийт 12,681,440,043 (арван хоёр тэрбум зургаан зуун наян нэгэн сая дөрвөн зуун дөчин мянга дөчин гурав) төгрөгийн татварын зөрчил илэрч, 964,557,700 (есөн зуун жаран дөрвөн всая мянга таван

зуун тавин долоон мянга долоон зуу) төгрөгийн нөхөн татвар, торгууль, алданги ногдуулсан байна.


Мэдүүлгийн хяналт шалгалтаар нэр бүхий албан тушаалтны 45,000,000 (дөчин таван сая) төгрөгийн хөрөнгө, орлогын эх үүсвэрийг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй буюу “үндэслэлгүй хөрөнгөжих” зөрчил гаргасныг илрүүлэн тогтоож, шүүхээр шийдвэрлүүлэхээр шилжүүлснээр Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхээс хууль бус хөрөнгийг улсын орлого болгох шийдвэр гаргалаа.

5.5 Гомдол, мэдээллийн хяналт шалгалтын ажлын талаар-2026 оны эхний хагас жилд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар хандсан 637 (өмнөх оны үлдэгдэл 61), нийт 698 гомдол, мэдээллийг хянан шалгахаас 598 гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн бөгөөд одоо 100 гомдол, мэдээлэл ажиллагаанд байна. Шийдвэрлэлт 85,7 хувьтай байна.

2026 оны эхний хагас жилд хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээллийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал хүлээн авсан гомдол, мэдээлэл 162 нэгжээр буюу 34.1 хувиар, хянан шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл 108 нэгжээр буюу 22,0 хувиар өссөн үзүүлэлттэй байна..

Хянан шалгасан гомдол, мэдээллээс 112 албан тушаалтанд холбогдох зөрчил тогтоогдож, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзэн эрх бүхий хэлтэст шилжүүлсэн 67, бусад байгууллагад харьяаллын дагуу шилжүүлсэн 109, бусад хэлтэст шилжүүлсэн 1, хуульд зааснаар хянан үзээгүй болон буцаасан 53, зөрчил илрээгүй 256 байна.

*Дүрслэл 4 Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт
(өмнөх оны мөн үетэй харьцуулбал)*



Гомдол, мэдээлэлд дурдсан нөхцөл байдлыг хянан шалгаж, ашиг сонирхлын зөрчил үүсэх эсхүл олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэх нөхцөлийг үүсгэж байгаа талаар мэдэгдэж, анхааруулан, хууль зөрчсөн албан хаагчдад хариуцлага ногдуулах болон хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар шаардлага хүргүүлж ажиллав.

Зөрчил гаргасан нь тогтоогдсон 47 албан тушаалтанд, үүнээс Авлигын эсрэг хуулийн 13.8.3-т зааснаар албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах шийтгэлийг 1, 13.9-д зааснаар албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах шийтгэлийг 2, 33.1.2-т зааснаар албан тушаалын цалингийн хэмжээг хуульд заасан хугацаа, хэмжээгээр хасах шийтгэл бууруулах сахилгын шийтгэлийг 16, 33.1.3-т зааснаар төрийн албанаас халах шийтгэлийг 3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29.2.2-т зааснаар албан тушаалын цалингийн хэмжээг

хуульд заасан хугацаа, хэмжээгээр хасах шийтгэлийг 23, 29.2.3-т зааснаар албан тушаалыг нь бууруулах сахилгын шийтгэлийг 2 албан тушаалтанд оногдуулах шаардлага хүргүүлснээс 34 албан тушаалтанд хариуцлага хүлээлгэсэн байна. Бусад шаардлагын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Хяналт шалгалтаар Мөрдөн шалгах хэлтэст харьяаллын дагуу шилжүүлсэн 62 гомдол, мэдээллээс нэр бүхий 4 албан тушаалтанд холбогдох эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт хүргүүлсэн байна.

Гомдол, мэдээллийн хяналт шалгалтаар нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгож, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах зөрчил тухайлбал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дугаартай тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ыг зөрчиж 30 000 000 (гучин сая) төгрөгийн хөнгөлөлттэй зээл, Засгийн газрын 2023 оны 185 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам”-ыг зөрчиж 5.375.670 (таван сая гурван зуун далан таван мянга зургаан зуун дал) төгрөгийн мөнгөн тэтгэмжийг бусдад давуу байдал болгон олгосон зөрчлийг тогтоож, ийнхүү хууль бусаар олгосон мөнгөн хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүллээ.

Хүлээж авсан нийт гомдол, мэдээллийн 51,2 хувийг Улаанбаатар хотоос, 48,8 хувийг орон нутгаас ирүүлсэн байна.

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, давтан гаргахгүй байх, үйл ажиллагаандаа хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар 60 байгууллага, албан тушаалтанд зөвлөмж, шаардлага хүргүүлж, үр дүнг тооцон ажиллалаа. Мөн Монгол Улсын Ерөнхий сайд, ЗГХЭГ-д санал хүргүүлж, эрх бүхий байгууллага, албан тушаалтантай хамтран ажиллаж байна. Тухайлбал,

- Нийгмийн даатгалын сангаас, нас барсан 721 иргэний нэрээр 2.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр үндэслэлгүй олгогдсоныг тогтоож, НДЕГ-аас 380 хүнтэй холбоотой 1831,6 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр нийгмийн даатгалын улсын байцаагчийн акт тогтоон, 233 хүнд холбогдох 1129.2 сая төгрөгийг бүрэн болон хэсэгчлэн барагдуулж, тэтгэврийн даатгалын санд нөхөн төлүүлэн, одоогоор 341 хүнд хамаарах 758.9 сая төгрөгийг нөхөн төлөх хариуцагчийг тодруулахаар НДЕГ-тай хамтран ажиллаж байна. Цаашид энэ төрлийн алдаа, зөрчлийг дахин гаргуулахгүйгээр таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, хяналт, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр холбогдох саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн бөгөөд Засгийн газрын ээлжит хуралдаанаар холбогдох саналууд хэлэлцэгдэж шийдвэр гарлаа.
- Нэр бүхий аж ахуйн нэгжүүдээс Хөгжлийн банканд төлбөр төлөх тухай шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удааширсан шалтгааныг тогтоож, хохирол барагдуулах боломжит хувилбарыг боловсруулан, саналыг Монгол Улсын Ерөнхий сайдад уламжлав.
- Хүүхдийн зуслангийн өмч хувьчлал, гэрээний хэрэгжилтийн нөхцөл байдал, хүүхдийн зусланг зориулалтын бусаар ашиглаж байгаа зөрчлийг арилгуулах, учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр ажиллаж, нөхцөл байдлыг тогтоон, улмаар "Соёл", "Өлзийт" хүүхдийн зуслангийн өмч хувьчлалыг хүчингүй болгуулах эсэх асуудлыг шийдвэрлүүлэхээр эрх бүхий байгууллагатай хамтран ажиллаж байна.


2026 оны эхний хагас жилд шалган шийдвэрлэсэн гомдол, мэдээллийн агуулгын хувьд албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулсан, хэтрүүлсэн 33.5 хувийг, бусдад давуу байдал олгосон 21.6 хувийг, ашиг сонирхлын зөрчил гаргасан 21,8 хувийг, хууль бус шийдвэр гаргасан 13.4 хувийг, бусад зөрчил 25.3 хувийг эзэлж байна.

Зургаа. Мөрдөн шалгах ажлын талаар:

6.1 Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл-2026 оны эхний хагас жилд өмнөх оны 103, энэ оны 988 гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, нийт 1091 гомдол, мэдээллийг


хянан үзсэнээс 233 гомдол, мэдээллийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу харьяалах байгууллагад нь шилжүүлсэн. Хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 5 Хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)



Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг холбогдсон албан тушаалын ангиллаар нь авч үзвэл, давхардсан тоогоор төрийн улс төрийн 154, төрийн захиргааны 247, төрийн тусгай 427, төрийн үйлчилгээний 122, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 110, бусад 43 байна.

Дүрслэл 6 Гомдол мэдээлэлд холбогдох албан тушаалын ангилал (өмнөх оны мөн үетэй харьцуулбал)



Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нийт 858 гомдол, мэдээллээс 362 гомдол, мэдээлэл буюу 42.2 хувьд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээж, 346 гомдол, мэдээлэл буюу 40.3 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, 18 гомдол, мэдээлэл буюу 2,1 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай тус тус прокурорт шилжүүлж, 132 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 84,6 хувьтай байна.

*Дүрслэл 7 Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн шийдвэрлэлт
(өмнөх оны мөн үетэй харьцуулбал)*




Мөрдөн шалгах хэлтэст хүлээн авч шалгасан 858 гомдол, мэдээллийн 459 буюу 53,5 хувийг Улаанбаатар, 399 буюу 46.5 хувийг орон нутгийн прокурорын хяналтын харьяалалтай гомдол, мэдээлэл эзэлж байна.

6.2 Эрүүгийн хэргийн талаар-Хуульд заасан харьяаллын 1769 үйлдэлтэй, 1034 холбогдогчтой, 1500 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсныг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 5,5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


Нийт шалгасан хэргийн 206 буюу 13,7 хувийг шүүхэд шилжүүлэх саналтай, 243 буюу 16,2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хаах, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай, 31 буюу 2,1 хувийг харъяаллын дагуу шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж, 48 хэргийг нэгтгэн шалгаж, 38 хэргийг түдгэлзүүлж, одоо 934 эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй байгаагаас хэрэг бүртгэлтийн 870 хэрэг, мөрдөн байцаалтын 64 хэрэг байна.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлт 35,2 хувьтай, шүүхээр 115 хэрэг шийдвэрлэгдсэн байна.

*Дүрслэл 8 Хэргийн шийдвэрлэлт
(өмнөх оны мөн үетэй харьцуулбал)*



Дүрслэл 9 Ажиллагаанд байгаа хэрэг
(өмнөх оны мөн үетэй харьцуулбал)




Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийг Эрүүгийн хуулийн зүйл хэсгээр ангилбал:

- Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл (Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах) гэмт хэрэг-1108 буюу 62,6 хувь;
- Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйл (Хахууль авах) гэмт хэрэг-215 буюу 12,2 хувь;
- Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйл (Хахууль өгөх) гэмт хэрэг-128 буюу 7,2 хувь;
- Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйл (Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах) гэмт хэрэг-18 буюу 1,0 хувь;
- Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйл (Үндэслэлгүйгээр хөрөнгөжих) гэмт хэрэг-51 буюу 2,9 хувь;
- Эрүүгийн хуулийн 22.12 дугаар зүйл (Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах) гэмт хэрэг-32 буюу 1,8 хувь;
- Бусад хэрэг 227 буюу 12,3 хувийг тус тус эзэлж байна.


Хэрэгт холбогдон шалгагдсан этгээдийн 152 буюу 14,7 хувийг төрийн улс төрийн, 292 буюу 28,2 хувийг төрийн захиргааны, 124 буюу 12,0 хувийг төрийн тусгай, 115 буюу 14,2 хувийг төрийн үйлчилгээний, 162 буюу 15,7 хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн, 189 буюу 18,3 хувийг бусад этгээд эзэлж байна.

Дүрслэл 10 Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан албан тушаалтан
(өмнөх оны мөн үетэй харьцуулбал)



2026 оны эхний хагас жилд шалгагдсан гэмт хэргийн улмаас 33,089,632,191 (гучин гурван тэрбум, наян есөн сая, зургаан зуун гучин хоёр мянга, нэг зуун ерэн нэг) төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 6,426,903,623 (зургаан тэрбум, дөрвөн зуун хорин зургаан сая, есөн зуун гурван мянга, зургаан зуун хорин гурав) төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 9,431,208,688 (есөн тэрбум, дөрвөн зуун гучин нэгэн сая, хоёр зуун найман мянга, зургаан зуун наян найм) төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

Дүрслэл 11 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт
(өмнөх оны мөн үетэй харьцуулбал)



6.3 Шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргийн талаар: 2026 оны эхний хагас жилд 115 хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн байна.

Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдээс дурьдвал:

- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын дарга Д.Г-д холбогдох;
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Б-д холбогдох;
- Хот байгуулалт, хөгжлийн газрын Дотоод хяналт, хуулийн хэлтсийн дарга Я.Б-т холбогдох;
- Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн дэд захирал Ц.Г, ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах газрын дарга П.Э, Сүхбаатар дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурор Э.А нарт холбогдох;
- Эрчим хүчний үндэсний төвийн захирал Д.Б-д холбогдох;
- Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ш.Ч нарт холбогдох;
- Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтсийн Захиргаа, хуулийн тасгийн дарга В.М нарт холбогдох;
- "Монголпросцветмет" ХХК /ТӨҮГ/-ын охин компани "Шижир алт" ХХК-ийн гүйцэтгэх захирал О.Б-т холбогдох;
- Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн Хяналт шалгалт, дотоод аудитын тасгийн дарга Г.А нарт холбогдох;
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хуулийн хэлтсийн шинжээч Г.Ж, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дарга М.Д нарт холбогдох;
- Баянзүрх дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн дарга Л.Ц нарт холбогдох;
- Хөшгийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга Я.С-д холбогдох;
- Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга Д.С нар холбогдох;
- Улаанбаатар төмөр замын төв эмнэлгийн дарга Б.Д нарт холбогдох;
- Сонгинохайрхан дүүргийн Газар зохион байгуулалтын албаны газар зохион байгуулагч Г.М-д холбогдох;

- Нийслэлийн Хяналт шалгалтын газрын мэргэжилтэн М.Ч-д холбогдох;
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн иргэний бүртгэлийн тасгийн ахлах улсын бүртгэгч З.А нарт холбогдох;
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч Г.А-т холбогдох
- Эх хүүхдийн эрүүл мэндийн төвийн төрсний дараах тасгийн эрхлэгч Ц.Б-д холбогдох гэх зэрэг.

2026 оны эхний хагас жилд эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх чиглэлээр олон улсын гэрээний хүрээнд гадаад улсын нутаг дэвсгэрт мөрдөн шалгах тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэхээр Австралийн Холбооны Улсын эрх бүхий байгууллагад 1, Бүгд Найрамдах Ирланд Улсын Хууль зүйн яаманд 1, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын эрх бүхий байгууллагад 1, АНУ-ын эрх бүхий байгууллагад 1, ОХУ-ын эрх бүхий байгууллагад 1 нийт 5 улсад Улсын ерөнхий прокурорын газраар уламжлан эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт хүргүүлсэн. Өмнөх онд явуулсан 1 эрх зүйн харилцан туслалцааны хүсэлтийн хариуг АНУ-аас хүлээн аваад байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авахуулахаар холбогдох хуулийн этгээдэд 77 мэдэгдэл хүргүүлснээс 55 мэдэгдлийн хариуг хүлээн авав.

ДҮГНЭЛТ

2026 оны эхний хагас жилд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигатай тэмцэх газрын үндэсний хөтөлбөр, байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээний хэрэгжилтийг ханган биелүүллээ.

- Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (OECD)-ын Зүүн Европ, Төв Азийн Авлигын эсрэг сүлжээ (ACN)-ний Үндэсний зохицуулагчаар УССГХ-ийн дарга, эрхэлсэн комиссар Б.Энхмэндийг томилж, тус байгууллагад албан ёсоор уламжлав.
- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын Зүүн Европ, төв Азийн Авлигын эсрэг сүлжээний бүгд хуралд танилцуулагдсан Истанбулын Авлигатай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 5 дугаар шатны мониторингийн тайланг хүлээн авсан бөгөөд холбогдох байгууллагуудад зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулахад бэлтгэж байна.
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2025 онд хэрэгжүүлэхээр 150 арга хэмжээний нэгдсэн тайланд ЗГХЭГ-тай хамтран Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 2025 оны хэрэгжилт дунджаар 66,8 хувьтай үнэлэгдлээ.
- Үндэсний аудитын газраас Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын хяналт шалгалтаар “Зөрчилгүй”, Төрийн ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны улсын нэгдсэн үзлэгээр 92.5 оноо (А)-той дүгнэгдлээ.
- Байгууллагын хэмжээнд 2026 оны эхний хагас жилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас хүлээн авсан гомдол, мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, өргөдөл, гомдол, мэдээлэл 331 нэгжээр буюу 21,9 хувиар, түүний дотор авлига, ашиг сонирхлын талаарх гомдол, мэдээлэл 162 нэгжээр буюу 34,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, хөрөнгө орлогын мэдүүлгийн (COIAD) бүрдүүлэлтийн системийг сайжруулах, Авлигатай тэмцэх газрын албан тушаалтнуудын ашигладаг тоног төхөөрөмжийг худалдан авах мэдээллийн

системийг нийлүүлэх, суурилуулах, үйл ажиллагаанд нэвтрүүлэх зорилгоор төслийн хүрээнд системийн хөгжүүлэлт хийснээр 2026 оны 4 дүгээр сард ХАСУМ-ийг цахимаар хүлээн авах, хянах, хариу хүргүүлэх дэд хэсэг, 2026 оны 5 дугаар сард Мэдүүлгийн ил тод байдлын цахим системийг үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүллээ.

- Албан хаагчдын болон хэлтэс, албадын мэдээлэл солилцооны хүрээг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй эхийн Mattermost мессенжерийг (chat.iaac.mn), мөн УССГХ-ийн сургалтын платформд зориулан нээлттэй эхийн Moodle платформыг дотоод сүлжээнд тохируулан туршилтад оруулав. GPS (track.iaac.mn) системд хурд хэтрэлтийн автомат сэрэмжлүүлгийг Mattermost руу хөгжүүлэн нэвтрүүлэв.
- tuss.io хиймэл оюун ухаант (AI) платформыг төрийн албаны ил тод байдал, хүнд суртал, иргэдэд чирэгдэл учруулахгүй байх, авлигын эрсдэлийг бууруулах зорилгоор үйл ажиллагаанд нэвтрүүлэн, ашиглаж байна.
- Төрийн үйлчилгээний лавлагаа e-Mongolia лавлагааны систем (lavlagaa.e-mongolia.mn) болон Смарт оффисын "Мөрдөгчийн тогтоол" модулийг 2026 оны 2 дугаар сарын 2-ны өдрөөс нэвтрүүлж, МШХ-ийн албан хаагчдад эрх олгож, гарын авлага бэлтгэн хүргэв.
- Гүйлгээнд бэлэн бус төлбөр тооцооны эзлэх хувийг нэмэгдүүлэх, төсвийн орлогын суурийг өргөжүүлэх, далд эдийн засгийн эзлэх хэмжээг багасгах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн төсөв, хөрөнгийн удирдлага ил тод, хараат бус, олон нийтийн хяналтад байх тогтолцоог бүрдүүлж, холбогдох яам, агентлаг, үндэсний зөвлөлийн эрх хэмжээ, хяналт, хариуцлагыг нэмэгдүүлэх талаар судалгаа хийж, холбогдох саналыг Засгийн газарт хүргүүлэв.
- Бэлэн бус төлбөр тооцооны эзлэх хувийг нэмэгдүүлэх, төсвийн орлогын суурийг өргөжүүлэх, далд эдийн засгийн хэмжээг багасгах, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг өсгөх арга замын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлсэн санал, зөвлөмжийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2026 онд нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс 150 тэрбум төгрөгөөр, тэтгэврийн нөөц санд байршуулсан хөрөнгөнөөс 85 тэрбум төгрөгөөр Засгийн газрын дотоод үнэт цаасыг тус тус худалдан авч, нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг эрсдэлгүй найдвартай эх үүсвэрт хөрөнгө оруулж, хүүгийн өгөөжөөр сангийн хөрөнгийг өсгөх боломжийг бүрдүүлэн ажиллаж байгааг хариу мэдээлэв.
- Авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах бүрэн эрхийн хүрээнд 10 салбарт хамаарах 75 шийдвэр, дүрэм, журам, гэрээг хянаж, тухайн дүрэм, журмыг бүхэлд нь хүчингүй болгох, хуульд заасан шаардлага хангуулах саналыг хүргүүлснээс эрх бүхий байгууллагаас 43 захиргааны хэм хэмжээний актад нэмэлт, өөрчлөлт оруулж, 11 актыг хүчингүй болсонд тооцож, 9 актад нэмэлт оруулан, 5 актыг бүхэлд нь хүчингүй болгон шийдвэрлээд байна. Хүргүүлсэн саналын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.
- Авлигын хор аюулыг ухуулан таниулах, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор төрийн байгууллагад 292 удаагийн сургалтад 24980 хүнийг хамран суралцуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал, сургалтад хамрагдсан хүний тоо 8973 нэгжээр буюу 56,0 хувиар, түүний дотор хувийн хэвшлийн ажилтнуудад чиглэсэн сургалтад хамрагдсан хүний тоо 1 дахин өссөн үзүүлэлттэй байна.
- Сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх, албан хаагчдын ачааллыг бууруулах зорилгоор Пүрэв гараг бүрийн 10 цагт цахим нэгдсэн сургалт хийдэг “4/10

хөтөлбөр"-ийг шинээр эхлүүлэв. Тус хөтөлбөрийн хүрээнд 9 удаагийн сургалтаар 1940 хүнийг цахим сургалтад хамрууллаа.

- Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж, төрийн байгууллагын 31 албан хаагчийг сургагч багшаар бэлтгэв.
- Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын 2025 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийг шинэчлэн бүртгэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулав. ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлэх хуулийн хугацаанд улсын хэмжээнд нийт төрийн болон нутгийн захиргааны нийт 131 байгууллагын 50236 мэдүүлэг гаргагч мэдүүлгээ мэдүүлж, баталгаажууллаа.
- Албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийн хяналт шалгалтаар өөрийн болон гэр бүлийн гишүүдийн татвар ногдуулах орлогоо үнэн зөв тайлагнаагүй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тул Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар 13 мэдүүлэг гаргагчид холбогдох мэдээллийг Татварын ерөнхий газарт шилжүүлснээр шалгалтаар нийт 12,681,440,043 (арван хоёр тэрбум зургаан зуун наян нэгэн сая дөрвөн зуун дөчин мянга дөчин гурав) төгрөгийн татварын зөрчил илэрч, 964,557,700 (есөн зуун жаран дөрвөн всая мянга таван зуун тавин долоон мянга долоон зуу) төгрөгийн нөхөн татвар, торгууль, алданги ногдуулсан байна.
- Мэдүүлгийн хяналт шалгалтаар нэр бүхий албан тушаалтны 45,000,000 (дөчин таван сая) төгрөгийн хөрөнгө, орлогын эх үүсвэрийг үндэслэлтэй тайлбарлаж чадаагүй буюу "үндэслэлгүй хөрөнгөжих" зөрчил гаргасныг илрүүлэн тогтоож, шүүхээр шийдвэрлүүлэхээр шилжүүлснээр Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхээс хууль бус хөрөнгийг улсын орлого болгохоор шийдвэрлэлээ.
- Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх гомдол мэдээллийн хяналт шалгалтаар нийтийн албан тушаалтан албан тушаалын эрх мэдлийг урвуулан ашиглаж, бусдад давуу эрх олгож, хууль бусаар олгосон 35,537,670 төгрөгийн хөнгөлөлттэй зээл, мөнгөн тэтгэмжийг төсөвт буцаан төвлөрүүлээ.
- Хяналт шалгалтын ажлын хүрээнд Нийгмийн даатгалын сангаас, нас барсан 721 иргэний нэрээр 2.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр үндэслэлгүй олгогдсоныг тогтоож, НДЕГ-аас 380 хүнтэй холбоотой 1831,6 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр нийгмийн даатгалын улсын байцаагчийн акт тогтоон, 233 хүнд холбогдох 1129.2 сая төгрөгийг бүрэн болон хэсэгчлэн барагдуулж, тэтгэврийн даатгалын санд нөхөн төлүүлэн, одоогоор 341 хүнд хамаарах 758.9 сая төгрөгийг нөхөн төлөх хариуцагчийг тодруулахаар НДЕГ-тай хамтран ажиллаж байна. Энэ төрлийн алдаа, зөрчлийг дахин гаргуулахгүйгээр таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, хяналт, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр холбогдох саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн бөгөөд Засгийн газрын ээлжит хуралдаанаар холбогдох саналууд хэлэлцэгдэж шийдвэр гарлаа.
- Хөгжлийн банканд төлбөр төлөх тухай шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удааширсан шалтгааныг тогтоож, хохирол барагдуулах боломжит хувилбарыг боловсруулан, саналыг Ерөнхий сайдад уламжлав.
- Хүүхдийн зуслангийн өмч хувьчлал, гэрээний хэрэгжилтийн нөхцөл байдал, хүүхдийн зусланг зориулалтын бусаар ашиглаж байгаа зөрчлийг арилгуулах, учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр ажиллаж, нөхцөл байдлыг тогтоон, улмаар "Соёл", "Өлзийт" хүүхдийн зуслангийн өмч хувьчлалыг хүчингүй болгуулахаар эрх бүхий байгууллагатай хамтран ажиллаж байна.

- Мөрдөн шалгах хэлтсээс хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан хэргийн тоо 5,5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- 2025 оны эхний хагас жилд 115 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн байна.
- 2026 оны хагас жилд шалгагдсан гэмт хэргийн улмаас 33,089,632,191 (*гучин гурван тэрбум, наян есөн сая, зургаан зуун гучин хоёр мянга, нэг зуун ерэн нэг*) төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 6,426,903,623 (*зургаан тэрбум, дөрвөн зуун хорин зургаан сая, есөн зуун гурван мянга, зургаан зуун хорин гурав*) төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 9,431,208,688 (*есөн тэрбум, дөрвөн зуун гучин нэгэн сая, хоёр зуун найман мянга, зургаан зуун наян найм*) төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна..

---000---